Химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнүүд, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах үйл ажиллагааг хариуцна” хэмээн заасны дагуу аюултай хог хаягдлын сав баглаа боодлыг эргүүлэн татаж тээвэрлэх, устгах үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл бүхий Мэргэжлийн байгууллагатай “Аюултай хог хаягдал тээвэрлэлтийн гэрээ” Гига Транс ХХК, “Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ”-г Түмэн Эгшиг ХХК-тай байгуулан ажилласан

1.2 ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА

1.2.1. Газрын гадарга

Газарзүйн байршлын хувьд Говь-Алтайн нурууны гол хэсэг болох Хантайширын нурууны үргэлжлэл тогтоц Хөх Сэрхийн нурууны баруун урд хэсэгт байрлана. Нурууны хамгийн өндөр цэг нь 3044,9 м өндөр Баян буурал уул, хамгийн нам цэг нь талбайн хилээс урд хэсэгт орших Бигэрийн хөндийн хүрээнд 1300 м байдаг байна. Хөх сэрхийн нуруу нь Алтайн нурууны салбар уулс учраас харьцангуй өндөр ихтэй, уулсын өндөр 300,0-700,0 м-ийн хэлбэлзэлтэй байдаг. Энд 2920,1 м өндөртэй Тахилт овоо байхаас гадна ихэнх уулс нь 2400 м-ээс дээш өндөртэй байна. Бигэрийн хөндий нь томоохон хотгор тогтоц бөгөөд талбай орчимд хөндийн өргөн нь 2-5 км өргөнтэй байна. Хөндийн төвийн хэсгийн 8 км орчим өргөнтэй хэсэг нь шаварлаг хурдсаар дүүргэгдсэн тэгш гадаргатай байдаг бол хөндийн 2 талаар эгц налуутай уулын хажуу үргэлжилнэ. Талбайн хойд хэсэг нь Алтайн нурууны үндсэн шинж болох томоохон сархиаг ихтэй, гуу жалгаар ихээхэн хэрчигдсэн, өндөр уулсын төрхийг хадгалж байдаг. Эдгээрийг хэрчсэн жалга, хөндийнүүд нь 100-300 м хүртэлх гүнтэй байдаг.

1.2.2. Уур амьсгал

Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, хоногийн болон жилийн хэмийн хэлбэлзэл ихтэй нутагт хамаарна. Зун нь халуун, өвөл нь харьцангуй дулаан байна. Зундаа хамгийн +38.3⁰ хүрэх ба дундаж нь +30⁰ орчим байна. Өвөлдөө хамгийн их хүйтэн нь -36.5⁰ хүрэх боловч дундаж нь -20⁰-аас хэтэрдэггүй.

1.2.3. Гадаргын ус

Жалга, хөндийн өргөн нь 50-100 м, зарим үедээ 200-300 м хүрэх боловч сайрын эхэн хэсэгт 10-20 м байх ба түүнээс ч нарийн болсон байна. Жалга хөндий нь ерөнхийдөө нэлээн урт бөгөөд зарим томоохон сайрууд нь 20-30 км урт байх нь элбэг. Зарим хөндийд нь жижиг гол горхи урсдаг. Эдгээр жалга, хөндийгөөр урссан түр зуурын ус талбайн өмнө хэсэгт орших томоохон хөндийд очиж жижиг нуур, тойрмуудыг үүсгэдэг. Эдгээрээс хамгийн том нь Бигэр нуур юм. Хайгуулын талбай болон ойр орчмын нутагт ундны болон ахуйн усны гол хангалт нь худаг болон гадаргуугийн усан хангамж бүхий ил урсацтай усан сан юм.

1.2.4. Гүний ус

Дөрөвдөгчийн пролювийн гаралтай нүх сүвний ус агуулагч коллекторт агуулагдана. Нүх сүвний коллектор нь сайр сайрга, дайр дайрга агуулсан элсэрхэг хурдсаар бүрдэнэ. Ус агуулагч давхарга нь 145 м хүртэл байрлах ба неогений ус үл нэвтрүүлэгч шаварлаг хурдсаар улана. Уст давхаргын зузаан нь 21.4-66.0 м дунджаар 47.1 м байна. Ус нь судалгааны талбайн хэмжээнд гол төлөв сульфат-гидрокарбонат кальци-магнийн бүрэлдэхүүнтэй, сулавтар цэнгэг, 0.9-1.9 г/л эрдэсжилттэй. Ерөнхий хатуулаг нь 10.84 аас 24.08 мг-экв/л. Гидрогеохимийн

агуулгаар кальци, магни, бичил элементээс хүнцлийн агуулга нь унд-ахуйн хэрэглээний усанд тавигддаг MNS 900:2018 стандартын шаардлагад нийцэхгүй болно. 2019 онд Гранд Электро Техноком ХХК нь Ханбөөр, эрээн будагт алт, зэсийн ордын Хан-алтай төслийн баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн газрын доорх усны эрэл-хайгуулын ажлыг хийж гүйцэтгэсэн.

1.2.5. Хөрсөн бүрхэвч

Төслийн талбайд сайр чулуурхаг цайвар хүрэн хөрс, уулын нимгэн хүрэн хөрс, уулын нугат хээрийн болон уулын нугын хөрс тархаж байна. 2019 оны 12-р сард хийсэн хөрсний дээжийн шинжилгээнд Ni, Cu, Pb Zn, Cr нь MNS 5850:2019 хөрсний чанарын стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байна.

1.2.6. Хур тунадас

Зундаа бороо бага орох бөгөөд өвөлдөө ч мөн цас бага унадаг гэсэн мэдээ бий, цасан бүрхүүл бараг байхгүй боловч зарим жилүүдэд 0.1-0.2 м хүрнэ. Жилийн хур тунадасны ихэнх нь зуны улиралд бороо хэлбэрээр ордог.

1.2.7. Ургамлын аймаг

Тухайн нутгийн цаг уур, хөрсний онцлогоос шалтгаалж ургамлын нягтшил багатай, их сийрэг тачир ургамал нь хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй энд тэнд хэсэг хэсгээрээ ургадаг боловч шимт чанартай байдгаараа онцлог юм. Энд агь шарилж, таана, мангир, хөмөл, хазаар, баглуур зэрэг олон наст ургамал, чихэр өвс, гоёо зэрэг эмийн ургамал, хайлаас, сухай, заг, бударгана, хармаг, харгана гэх мэтийн модлог, бутлаг говийн ургамал ургадаг. Хавар 4-р сараас ургамал ургаж цэцэг, навчаа дэлгэж эхлэх ба намар 9-р сараас гандах байдалтай болж ирнэ.

1.2.8. Амьтны аймаг

Энд чоно, хярс, үнэг, өмхий хүрэн, мануул мэтийн махчин амьтад, хойлог, тас, харцага, элээ, ногтруу, тагтаа, болжмор, хулан жороо мэтийн жигүүртэн, гүрвэл, могой мэтийн хэвлээр явагч, туулай, алаг даага, бозлог мэтийн мэрэгчид, аалз, арваалж, ямаан ууц мэтийн шавж амьдардаг.

1.2.9. Тусгай хамгаалалттай газар нутаг

Тус төслийн нутаг дэвсгэр нь улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон орон нутгийн тусгай хамгаалалтын газар нутагтай давхцалгүй байна. Харин төсөл хэрэгжих талбайн баруун захад Цахир Булаг нэртэй Аймгийн ОНТХГН байрлаж байна.

1.2.10. Нийгэм-эдийн засаг

Дүүрэг нутгийн хүрээнд хүн амын нягтрал маш бага бөгөөд талбайн ойр орчимд бараг айл нутагладаггүй. Талбайгаас 50 км зайд орших Бигэр сум дээр хүн эмнэлэг, сургууль, холбоо, банкны салбар, ШТС болон жижиг үйлчилгээний газруудтай. Тээврийн үндсэн төрөл нь автомашин, мотоцикл бөгөөд аймаг, сум, баг шороон замаар холбогддог. Хүн амын ихэнх нь халхууд бөгөөд хүн ам цөөтэй дийлэнх нь мал аж ахуй эрхэлдэг ба гар аргаар алт олборлогчид нэлээдгүй байдаг. Малын бүтцийн дийлэнх нь ямаа, хонь, тэмээ үлдсэн бага хувийг адуу, үхэр эзэлнэ. Харин ордоос баруун тийш 120 орчим км-т Цээл сумын нутагт орших “Алтайн хүдэр” ХХК-ийн Таян нуурын төмрийн хүдрийн уурхай ажилладаг бөгөөд уг уурхай нь Говь-Алтай аймгийн Алтай сумын нутагт орших Бургастайн хилийн боомт хүртэлх 168 км сайжруулсан технологийн замаас 50 км-т өндөр даацын зам тавьсан байна. Цаашид замаа үргэлжлүүлэн тавьж дуусгах төлөвлөгөөтэй байгаа зэрэг нь эдийн засгийн хувьд эерэг үзүүлэлт болж байна.

1.3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1.3.1 Газрын гадарга, хэвлийд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Уурхайн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв. Үүнд:

Хүснэгт 6. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохiolдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
1.	Исэлдсэн болон анхдагч хүдэр боловсруулах үйлдвэрийн ашиглалтын 7 жилийн хугацаанд нийт 148.26 га талбай, 89.7 мян.м ³ үржил шимт хөрс үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх, бүрэн устах	Зайлиггүй				x	
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
2.	Үйлдвэрийн буцлах болон бөөнцөглөх хэсгээс агаарт тоосжилт үүсэх, улмаар цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан 50-250 м зайд тархах, орчныг бохирдуулах	Зайлиггүй					
		Боломжтой				x	
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
3.	Үйлдвэрийн технологийн үйл ажиллагаа нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг, ялангуяа үйлдвэрийг барьж байгуулах үед газрын гадарга, хөрс, түүний геологийн тогтоц, хэвлийд өөрчлөлт гарах	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй			x		
		Магадлал муутай					
		Ховор					
БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
	Үйлдвэрийн талбайгаас эргэн тойрон 100 метр зайд хөрс, ургамал халцрах болон	Зайлиггүй					
		Боломжтой		x			

4.	талхлагдах, зам харгуй гарах зэргээр сөрөг нөлөөлөл бий болох	Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
5.	Нөлөөллийн хүрээнээс гадагш 200 метр дотор хүний үйл ажиллагаа, машин техникийн нөлөөлөл үүсэх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай		x			
		Ховор					
6.	Үйлдвэрийн ашиглалтын талбай орчмын ургамал талхлагдах, хөрс хуулалтын үлмаас үйлдвэрийн талбай орчмын ургамлан нөмрөг бүрэн устахын зэрэгцээ орчны талбайн ургамал, шимт хөрсний гадаад овоолгод түр хугацаанд дарагдах	Зайлиггүй					
		Боломжтой				x	
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
7.	Ашиглалтын жилүүдэд бэлчээрийн эдэлбэр газар багасаж, газрын өнгө төрх өөрчлөгдөх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй			x		
		Магадлал муутай					
		Ховор					
	НИЙТ			2	2	3	-
	ЭЗЛЭХ ХУВЬ (%)			28.6	28.6	42.8	-

	ДҮГНЭЛТ	Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөллийн эрчим, цар хүрээг авч үзэхэд 57.2 % нь “Бага” болон “Дунд”, 42.8 % нь “Их” гэсэн ангилалд хамрагдаж байгаа бөгөөд тохиолдох магадлалаар авч үзвэл 28.6 % нь тус бүр зайлиггүй болон боломжтой нөлөөлөлд хамрагдаж байна. Тиймээс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөллийг “Их” гэж дүгнэв. Учир нь төсөл хэрэгжүүлэх үе шатанд дээрх нөлөөллийг бууруулах юм уу арилгах аргагүй юм. Гэхдээ энэхүү нөлөөллийн хамрах хүрээ нь тухайн заасан хэмжээнээс хэтрэхгүй бөгөөд төсөл хэрэгжүүлэх явцад уг үйлдвэрийн техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөв. тул
--	---------	--

1.3.2 Уур амьсгалын хүчин зүйлд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Уур амьсгалын хүчин зүйлд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв

Хүснэгт 7. Уур амьсгалын хүчин зүйлд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
1	Химийн бодисын хадгалалтын горим хангахгүй нөхцөлд хадгалбал хэт хөрснөөс талсжих, халснаас ууришиж дотоод даралт нэмэгдэх, дулаанд тогтворгүй бүтээгдэхүүн үүсэх, нарны гэрэл болон хэт ягаан туяанаас исэлдэх, полимержих зэргээр бүтээгдэхүүний шинж чанар өөрчлөгдөх, өндөр температур хэт халснаас тэсэрч, дэлбэрэх, галын аюул гарах, бүтээгдэхүүний чанар өөрчлөгдөх, асгарч алдагдах.	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
2	Шингэн төлөвтэй бодисууд дулааны нөлөөгөөр тэлэх, улмаар хальж асгарах	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
3	Хадгалах температурын өөрчлөлт, хэт их халалтаас шалтгаалан найрлага шинж чанарт өөрчлөлт орох	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
		Ховор	х				
4	Аянга цахилгаан, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр тэсэрч дэлбэрэх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
	НИЙТ		4	-	-	-	-
	ЭЗЛЭХ ХУВЬ (%)		100	-	-	-	-
	ДҮГНЭЛТ	Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтаас уур амьсгалд үзүүлэх нөлөөлөл нь 100 % маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд харин тохиолдох магадлал нь ховор гэсэн ангилалд хамрагдаж байна. Цаг уур, уур амьсгалд үзүүлж болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, ялангуяа Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан болзошгүй осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан тохиолдолд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх боломжтой юм.					

1.3.3 Агаарын чанарт үзүүлэх гол болзошгүй сөрөг нөлөөлөл

Агаарын чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 8. Агаарын чанарт үзүүлэх гол болзошгүй сөрөг нөлөөлөл

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
1	Үйлдвэрийн барилгын ажлын үед хөрс хуулах, тээвэрлэх болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд өртсөн ухмал, овоолгын талбайгаас ашиглалтын нийт хугацаанд тоосжилт үүсэх.	Зайлишгүй				x	
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
2	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх хамгийн гол агаар бохирдуулагч бодисын орон зайн тархалтын үр дүнгээс үзэхэд нийт тоосонцор буюу TSP хамгийн ихдээ ялангуяа үйлдвэрийн дотоод тээврийн замын бүсэд 200-340 мкг/м ³ буюу Монгол улсын гадаад орчны MNS 4585:2016 стандартын жилийн ЗДХ болох 100 мкг/м ³ агууламжаас 2-3 дахин давж болзошгүй байна. PM10 тоосонцор үйлдвэр орчим мөн адил хамгийн их агууламж 60-110 мкг/м ³ хүртэлх агууламжтайгаар стандартын жилийн дундаж ЗДХ болох 50 мкг/м ³ агууламжаас 1-2 дахин давж байгаа нь үйлдвэрийн ажиллагсдад сөргөөр нөлөөлж болзошгүй байна.	Зайлишгүй					
		Боломжтой			x		
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
3	Химийн бодисын агуулахад химийн бодистой харьцан ажиллах үед санамсаргүй асгах, алдах, агуулахын шал, гадаад орчинд асгарсанаас ажлын байрны орчны	Зайлишгүй					
		Боломжтой					
		Магадгүй					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
	агаарт нөлөөлөх	Магадлал муутай					
		Ховор	х				
4	Химийн хорт болон аюултай бодис агуулж байгаа сав нь хэт удаан хадгалах, нарны гэрэл тусах, хөлдөх, халах, зэврэх, урвалд орох зэргээс эвдрэх, цоорох, зөөлрөх зэрэг гэмтлээс шалтгаалан асгарч алдагдах, ажлын байрны агаарт тархах	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай		х			
		Ховор					
5	Химийн хортой болон аюултай бодисыг гадна талбайд ил задгай хаяснаас агаарт тэсрэмтгий хольц үүсгэх, гадаад орчинд агаарын урсгалаар дамжин нөлөөлөх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй			х		
		Магадлал муутай					
		Ховор					
6	Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас ууришмтгай, дэгдэмхий бодисууд агаарт ууриших, исэлдэн урвалдах зэргээр агаарын чанар найрлагад нөлөөлөх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
7	Химийн бодистой шатах, гал авалцах эх үүсвэрийг ойр байлгаснаар гал түймэр гарах, тэсэрч дэлбэрснээр хортой хий ялгаран агаарын чанар, хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
8	Тухайн бодисыг хадгалах үед хор	Зайлиггүй					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маши бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
	аюулын лавлах мэдээлэлд заасан хадгалах нөхцөлийг хангасан орчныг агуулахад бүрдүүлээгүйгээс агаарын найрлага өөрчлөгдөх, улмаар хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Боломжтой		х			
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
	НИЙТ		3	2	2	1	-
	ЭЗЛЭХ ХУВЬ (%)		37.5	25.0	25.0	12.5	-
	ДҮГНЭЛТ	Төслөөс агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн 75 % бага, маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалаар нь авч үзвэл ховор нөлөөллийн ангилалд 37.5% нь хамрагдсан байна. Нөлөөллийн эрчим цар хүрээгээр нь авч үзвэл дунд болон их нөлөөлөл мөн 37.5%-ийг эзэлж байгаа бол, тохиолдох магадлалаар нь авч үзвэл зайлиггүй болон боломжтой нөлөөлөл ихэнх хувийг эзэлж байгааг харгалзан төслөөс агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн –Дунд гэж дүгнэв.					

1.3.4 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Уурхайн бэлтгэл ажил.

Хан-Алтайн алтны үндсэн ордыг ашиглах уурхайн бэлтгэл ажил олборлолтын эхний жилд шимт хөрс хуулах, зам засах, хүдрийн овоолго болон хөрсний овоолгын талбай бэлдэх, баяжуулах үйлдвэрийн хаягдлын далангийн суурь бэлтгэх ажлууд хийгдэнэ. Уурхайн үндсэн болон туслах тоног төхөөрөмжийг ашиглан эдгээр ажлыг гүйцэтгэнэ. Исэлдсэн болон анхдагч хүдэр боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд нийт хугацаанд 148.26 га талбай элэгдэл эвдрэлд өртөхөөр байна.

Уурхайн гадаад болон дотоод зам.

Уурхайгаас хөрсний 1, 2-р овоолго болон хүдрийн түр овоолго, баяжуулах үйлдвэр хүртэл сайжруулсан шороон зам тавигдана. Уурхайн замын уулзваруудыг өргөтгөх, зам бэлтгэх ажлыг гүйцэтгэхэд 120.8 мян.м3 газар шорооны ажил хийгдэнэ.

Шимт хөрсний овоолго.

Боловсруулах үйлдвэрийг ашиглах үйл ажиллагаанд нийт хугацаанд 148.26 га талбай элэгдэл эвдрэлд өртөхөөр байна. Төсөл хэрэгжих талбайн газрын гадарга нь өндөр уулын бүсэд хамаарах бөгөөд чулуу их, өнгөн хөрсний давхарга маш нимгэн, хүчтэй угаагдалд орсон байна. Тиймээс “Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS 5916:2008 стандартын 5.6 дахь хэсэгт “Дайргархаг, хайргархаг, чулуурхаг бүтэцтэй ба хүчтэй угаагдсан хөрсөнд шимт үеийг хуулах норм тогтоохгүй” гэж заасны дагуу үржил шимт хөрсийг 0.05-0.07 см-ээр хуулахаар төлөвлөв. Төслийн үйл ажиллагаанаас 148.26 га талбай элэгдэл, эвдрэлд өртөх бөгөөд үржил шимт хөрсийг 0.05 см, сийрэгжилтийн коэффициентийг 1.21-ээр тооцон MNS 5916:2008 стандартын дагуу 89.7 мян.м3 шимт хөрсийг хуулж, хадгалахаар төлөвлөв.

Хүдрийн овоолго.

Хүдрийн түр овоолгыг хүдрийн овоолго болон бага агуулгатай хүдрийн овоолго гэж ялган хураана. Ил уурхайн дэргэдэх хүдрийн түр овоолго нь баяжуулах үйлдвэрийг 14 хоног хангах нөөцийг хадгалах багтаамжтай байна. Хүдрийг баяжуулах үйлдвэрийн дэргэдэх хүдрийн агуулах хүртэл 7.7 км тээвэрлэнэ. Баяжуулах үйлдвэрийн дэргэдэх хүдэр ба бага агуулгатай хүдрийн агуулах руу нийт уулын ажлаар 10,107.03 мян.тн хүдэр олборлоно. Үүнээс хүдэр 7,978.9 мян.тн, бага агуулгатай хүдэр 2,128.07 мян.тн байна. Ашиглалтын 2 дахь жилээс баяжуулах үйлдвэр ажиллаж эхлэх учраас баяжуулах үйлдвэрийн дэргэд ашиглалтын 1 дэх жилээс 575.6 мян. м3 багтаамжтай хүдрийн түр агуулах үүснэ.

Хүснэгт 9. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах

№	Нөлөөллүүд	Нөлөөллий эрчим, цар хүрээТөхиолдохм агадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
1	Исэлдсэн болон анхдагч хүдэр боловсруулах үйлдвэрийн ашиглалтын 7 жилийн хугацаанд нийт 148.26 га талбай, 89.7 мян.м ³	Зайлшгүй				х	
		Боломжтой					
		Магадгүй					

№	Нөлөөллүүд	Нөлөөллий эрчим, цар хүрээТохиолдох агадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
	үржил шимт хөрс үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх, бүрэн устгах	Магадлал муутай					
		Ховор					
2	Үржил шимт хөрсний овоолго, хөрсний гадаад овоолго, чанарын бус хүдрийн овоолгод ашиглалтын 7 жилийн хугацаанд газрын гадаргад 10 м өндөртэй, 48.31 га талбайг эзэлсэн овоолго бий болж хөрсөн бүрхэвчийг дарах	Зайлиггүй				х	
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
3	Барилга байгууламжууд (үйлдвэрийн болон дэд бүтцийн), технологийн зам талбай, шугам шуудуу, цахилгааны дэд станц, усны өргөх станц, цэвэр ба үерийн усны сан зэрэг дэд бүтцэд ашиглагдах газруудад үүсэх хөрсөн бүрхэвчийн эвдрэл	Зайлиггүй					
		Боломжтой			х		
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
4	Үйлдвэрийг барьж байгуулах үеийн болон ашиглалтын үеийн ердийн хөрсөн замын нөлөөгөөр үүсэх өнгөн хөрсний талхагдал	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй			х		
		Магадлал муутай					
		Ховор					
5	Шинээр ашиглагдах газруудын шимт хөрсний хуулалт, тээвэрлэлт, хадгалалтын явцад үүсэх хөрсний бүтцийн алдрал	Зайлиггүй					
		Боломжтой			х		
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдохм агадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
6	Анхдагч хүдэр боловсруулах үед буюу бутлах шигших үед ялгарах тоосжилтоос ердийн өнгөн хөрсөнд үзүүлж болзошгүй хүнд металлын бохирдлын сөрөг нөлөөлөл	Зайлишгүй					
		Боломжтой					
		Магадгүй		x			
		Магадлал муутай					
		Ховор					
7	Нуруулдан уусгах талбай, химийн бодисын агуулах, баяжуулах үйлдвэрийн байгууламжууд, хаягдал хадгалах талбай зэрэг хорттой химийн бодис урвалж ашигладаг объектуудаас үүсэх болзошгүй химийн бохирдлын сөрөг нөлөөлөл	Зайлишгүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай		x			
		Ховор					
8	Техник тоног төхөөрөмжийн эвдрэлээс болон тос тослох материалын агуулах савнаас тос, масло алдагдах болзошгүй органик бохирдлын сөрөг нөлөөлөл	Зайлишгүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор		x			
9	Ахуйн болон хүнсний гаралтай хатуу шингэн хог хаягдлаас үүсэх болзошгүй механик болон нянгийн бохирдлын сөрөг нөлөөлөл	Зайлишгүй					
		Боломжтой					
		Магадгүй		x			
		Магадлал муутай					
		Ховор					
10	Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдол, химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтыг горим алдагдсанаар	Зайлишгүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маши бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
	хөрсөнд их хэмжээгээр шингэх, хөрсөн бүрхэвчинд сөрөг нөлөөлөх	Ховор	х				
11	Химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг хөрсөнд алдаж, түүний найрлага бүтцийг өөрчлөх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
12	Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдсанаар ургамалжилт, хөрсний бичил биетэнд дам нөлөөлөл үзүүлэх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
	НИЙТ		3	4	3	2	-
	ЭЗЛЭХ ХУВЬ (%)		25.0	33.3	25.0	16.7	-
	ДҮГНЭЛТ	Төслөөс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийн 58.3% нь бага, маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалаар нь авч үзвэл ховор болон магадлалтай, боломжтой ангилалд 66.6% нь хамрагдсан байна. Мөн нөлөөллийн эрчим цар хүрээгээр нь авч үзвэл дунд болон их нөлөөлөл 41.7 %-ийг эзэлж байгаа бол, тохиолдох магадлалаар нь авч үзвэл зайлиггүй болон боломжтой нөлөөлөл ихэнх хувийг эзэлж байгааг харгалзан төслөөс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийг “Их ” гэж дүгнэв. Нөлөөллийн үнэлгээнд хамрагдсан гол нөлөөллийг буруулах юм уу арилгах боломжгүй, зайлиггүй тохиолдох нөлөөлөл тул “Их ” гэсэн ангилалд хамруулав.					

1.3.5 Гадаргын болон гүний усанд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас гадаргын болон газар доорх усны нөөц, чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 10. Гадаргын болон гүний усанд үзүүлэх гол болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
1	Төслийн ус хангамжийн цооног байрлах газрын доорх усны нөөц хомсдох	Зайлиггүй					
		Боломжтой			x		
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
2	Төслийн талбайн газрын доорх усыг их хэмжээгээр татан авах нөхцөлд газрын доорх усны түвшин, урсцын чиглэлд өөрчлөлт гарах	Зайлиггүй					
		Боломжтой			x		
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
3	Хаягдлын сангийн усан дахь бохируулагч бодисоор газрын доорх ус бохирдох, шүүрэл үүсэх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор		x			
4	Химийн бодисын хэрэглээ, шатах тослох материалыг газрын гадарга, хөрсөн бүрхэвчид алдсанаар хөрсөн бүрхэвч, ургамал нөмрөг бохирдож, улмаар агаарын хур тунадасны угаагдлаар бага	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
	гүний ус бохирдох	Ховор		х			
5	Унд-ахуйн усны эх үүсвэр болох гүний худагт ариун цэврийн болон хамгаалалтын бүс тогтоогоогүйгээс бохирдох	Зайлиггүй					
		Боломжтой			х		
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
6	Үер усны аюул, байгалийн гамигаас шалтгаалан хаягдлын сан, нуруулдан уусгалтын талбайн үерийн усны далан сэтрэх, ханийн бэхлэгээ нурснаас бохир ус алдагдаж гадаргын болон гүний усыг бохирдуулах	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
7	Тээвэрлэх, хүлээн авах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг түр урсцын голдирлуудад асгах, талбайд татан ирэх явцад бохирдлын эх үүсвэрийг бий болгох	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
8	Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөл т, гүйцэтгэлийн доголдоос үүдэн газрын гадаргад химийн бодис алдагдах, улмаар түүний урсцаар тархаж, голдирлын дагуух усыг бохирдуулах	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор		х			
	Усан орчинд урт болон богино	Зайлиггүй					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маши бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
9	хугацааны хурц хоруу чанартай, усны амьд организмд хортой зэрэглэлд хамаарах бодисын хадгалалт, ашиглалтыг зохих журмын дагуу явуулаагүйгээс усан орчинд сөрөг нөлөөлөх	Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
10	Ахуйн бохир усыг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, бохир ус хадгалах сан байгуулаагүйгээс хөрсөнд хаягдаж бохирдол үүсгэх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай		х			
		Ховор					
	НИЙТ		-4	-4	-3		
	ЭЗЛЭХ ХУВЬ (%)		36.4	36.4	27.3		
	ДҮГНЭЛТ	Төслөөс гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийн эрчим, цар хүрээгээр авч үзэхэд 72.8 % нь бага, маш бага буюу нөлөөгүй, тохиолдох магадлалаар нь авч үзвэл ховор болон магадлал муутай нөлөөлөл 81.8%-ийг тус тус эзэлж байна. Харин нөлөөллийн эрчим, цар хүрээгээр дунд ангилалд 27.3 %-ийг эзэлж байгааг харгалзан усан орчинд үзүүлэх нөлөөллийг “Бага” гэж дүгнэв.					

1.3.6 Ургамлан бүрхэвчинд үзүүлэх гол болон сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Төслийн зайлшгүй үйл ажиллагаатай холбоотойгоор уурхайн эдэлбэр газар болон түүний ойр орчмын ургамлан бүрхэвчийг устгаснаас үүдэх дам сөрөг нөлөөллүүд нь хөрс эвдрэлд өртөмхий болох, хөрсний сул шороо агаарт дэгдэж агаар дахь тоосжилтыг нэмэгдүүлэх, улмаар энэ нь эргээд ургамлын ургах нөхцөл болон хүрээлэн буй орчинд шууд болон дам хэлбэрээр нөлөөлж болзошгүй юм.

Уурхайн үйл ажиллагааг явуулах үед орчны ургамлан бүрхэвчинд доор дурдсан сөрөг нөлөөллүүд учирч болзошгүй байна. Үүнд:

Хүснэгт 11. Ургамлан бүрхэвчинд үзүүлэх гол болон сөрөг нөлөөлөл, үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн орчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
1	Исэлдсэн болон анхдагч хүдэр боловсруулах үйлдвэрийн ашиглалтын 7 жилийн хугацаанд нийт 148.26 га талбай, 89.7 мян.м ³ үржил шимт хөрс, ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөх, бүрэн устгах	Зайлиггүй				х	
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
2	Үржил шимт хөрсний овоолго, хөрсний гадаад овоолго, чанарын бус хүдрийн овоолгод ашиглалтын 7 жилийн хугацаанд Газрын гадаргад 10 м өндөртэй, 48.31 га талбайг эзэлсэн овоолго бий болж ургамлан нөмрөг дарагдах	Зайлиггүй				х	
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
3	Нуруулдан уусгах талбай, химийн бодисын агуулах, баяжуулах үйлдвэрийн байгууламжууд, хаягдал хадгалах талбай зэрэг хорттой химийн бодис урвалж ашигладаг объектуудаас үүсэх болзошгүй химийн бохирдлын сөрөг нөлөөлөл	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй			х		
		Магадлал муутай					
		Ховор					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн орчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
4	Техник тоног төхөөрөмжийн эвдрэлээс болон тос тослох материалын агуулах савнаас тос, масло алдагдах болзошгүй органик бохирдлын сөрөг нөлөөлөл	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
5	Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдол, химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтыг горим алдагдсанаар хөрсөнд их хэмжээгээр шингэх, ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай	х				
		Ховор					
6	Химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг хөрсөнд алдаж, ургамлан нөмрөгт нөлөөлөл	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй	х				
		Магадлал муутай					
		Ховор					
7	Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдсанаар ургамалжилт, хөрсний бичил биет, ургамлан нөмрөгт дам нөлөөлөл	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
	Ургамлан бүрхэвчийг устгаснаас үүдэх дам сөрөг нөлөөллүүд нь хөрс эвдрэлд өртөмхий болох, хөрсний сул шороо агаарт дэгдэж агаарын тоосжилтыг нэмэгдүүлэх, улмаар	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн орчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
8	энэ нь эргээд ургамал болон байгаль орчинд шууд болон дам хэлбэрээр нөлөөлөх	Магадлал муутай					
		Ховор		х			
9	Ургамлан нөмрөгийн фотосинтезийн идэвх буурах, өсөлт удааширах улмаар өсөлт нь бүрмөсөн зогсож ургахаа болих	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй			х		
		Магадлал муутай					
		Ховор					
10	Үйлдвэр ашиглалтын үед замын маршрут тогтоогоогүйгээс замбараагүй олон салаа зам гарах, ургамлан нөмрөг талхлагдах	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
11	Үйлдвэрийн талбайн нөлөөллийн бүсийн эргэн тойрон 100 метр зайд хөрс, ургамал халцрах болон талхлагдах, зам харгүй гарах зэргээр сөрөг нөлөөлөл бий болох	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай	х				
		Ховор					
12	Нөлөөллийн хүрээнээс гадагш 200 метр дотор хүний үйл ажиллагаа, машин техникийн нөлөөлөл үүсэх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй	х				
		Магадлал муутай					
		Ховор					
	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас техник технологийн гэнэтийн эвдрэл гэмтэл болон ажилчдын	Зайлиггүй					
		Боломжтой					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн орчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
13	санаандгүй алдаанаас хөрс шатах тослох материалаар бохирдох, улмаар ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөх	Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
	НИЙТ		-4	-1	-1	-2	
	ЭЗЛЭХ ХУВЬ (%)		50.0	12.5	12.5	25.0	
	ДҮГНЭЛТ	Төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн эрчим, цар хүрээг авч үзэхэд 62.5 % нь бага, бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалаар авч үзвэл 37.5 % нь ховор тохиолдох, магадлалтай байна. Харин “Дунд болон Их” гэсэн ангилал 37.5% нь хамрагдаж байгаа бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед ашиглагдах талбайн ургамлан нөмрөг бүрэн устах, нөлөөлөлд хүчтэй өртөхөөр байгаа бөгөөд тохиолдох магадлалаар нь авч үзвэл зайлиггүй ангилалд хамрагдаж байна. Учир нь төсөл хэрэгжүүлэх үе шатанд дээрх нөлөөллийг бууруулах юм уу арилгах аргагүй юм. Гэхдээ энэхүү нөлөөллийн хамрах хүрээ нь тухайн заасан хэмжээнээс хэтрэхгүй бөгөөд төсөл хэрэгжүүлэх явцад ашиглагдсан талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх тул нөлөөллийг бууруулах боломжтой байна.					

1.3.7 Амьтны аймагт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Төслийн бүтээн байгуулалтын явцад уурхайн зөвшөөрөл бүхий талбайд ан амьтны амьдрах орчин алдагдана. Төслийн зүгээс амьтны аймагт сөрөг нөлөөлөл учруулж болохуйц газар нь уурхайн зөвшөөрөл бүхий талбай болох бөгөөд энэ нь тус бүс нутгийн биологи газарзүйн бүсийн нийт хэмжээтэй харьцуулахад маш бага талбай юм. Бүтээн байгуулалт болон уурхайн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл нь тэсэлгээ, дуу чимээ, гэрэл чийдэн болон машин техникийн хөдөлгөөн зэрэг хүчин зүйлүүд байх бөгөөд төслийн бүс нутгийн ойролцоо зэрлэг ан амьтныг үргээж, энэ орчимд байрших амьтдын тоог бууруулж болзошгүй. Мөн тухайн орчинд ажиллаж, амьдрах хүний тоо нэмэгдсэнээр ан агнуур хийх явдал ихсэж, ан амьтанд сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй.

Хүснэгт 12. Амьтны аймагт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Хүснэгт 12. Амьтны аймагт үзүүлэх гол болон бодьмасын сөрөг нөлөөлөл, үнэлгээ							
№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
1	Исэлдсэн болон анхдагч хүдэр боловсруулах үйлдвэр, түүнийг дагасан үндсэн болон туслах барилга байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалт, газар шорооны ажлын үед мэргэгч болон мөлхөгч амьтдын амьдрах орчин устаж үгүй болох, тоо толгой цөөрөх	Зайлишгүй				x	
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
2	Үйлдвэрийн үйл ажиллагааны үед тухайн орчны сээр нуруугүйтэн амьтдын амьдрах орчныг хязгаарлаж, тоо толгойг цөөрүүлэх	Зайлишгүй					
		Боломжтой			x		
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
3	Үйлдвэр, уурхайн тээвэрлэлтийн үед ашиглах хүнд даацын машин механизм, автомашинуудын хөдөлгөөнөөс үүсэх дуу чимээ, гэрэл, хорт утаа, газар шорооны ажилтай холбоотойгоор үүсэн бий болох тоосжилт зэргээс үүдэн тухайн ажил явагдаж байгаа газрын ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах	Зайлишгүй					
		Боломжтой			x		
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
4	Аливаа нэгэн зүйл устаж, дайжиж алга болсонтой холбоотойгоор экологийн идэш тэжээлийн харилцаа холбоо алдагдах	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор		x			
5	Тухайн нутагт нутагладаг зэрлэг амьтад болон мал үйлдвэрийн ухааш, шуудуудунд унаж бэртэх, хорогдох	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	x				
6	Агнуурын ач холбогдолтой, ховордож буй болон улаан номд орсон төрөл зүйлийг үйлдвэрийн ажилчид хулгайгаар агнах	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	x				
НИЙТ			-2	-1	-2	-1	-
ЭЗЛЭХ ХУВЬ (%)			33.3	16.7	33.3	16.7	-
ДҮГНЭЛТ		Төслөөс амьтны аймагт үзүүлэх нөлөөллийн эрчим, цар хүрээг авч үзэхэд 50 % нь бага, бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалаар авч үзвэл 33.3 % нь ховор тохиолдох магадлалтай байна. Мөн –Дунд болон Их\ гэсэн ангилал 50% нь хамрагдаж байгаа бөгөөд үйлдвэрийн үйл ажиллагаа, дэд бүтэцтэй холбогдон ан амьтны байршил нутаг алдагдах, чимээ шуугиан, гэрлийн нөлөөгөөр ан амьтан үргэх, дайжих нөлөөлөх байдлын үнэлгээг “ДУНД ” гэж дүгнэв.					

1.3.8 Нутгийн оршин суугчид болон ажиллагсдын эрүүл мэндэд учруулах гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Хан Алтайн алтны үндсэн ордын Боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааны явцад хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллийг нэгтгэн авч үзье. Үүнд:

- Үйлдвэрийн үндсэн болон туслах барилга байгууламжийн хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарах.
- Мэргэжилтэн, ажилтны чадваргүй байдал, хариуцлагагүй үйлдэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс ажлын байранд аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүн алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх.
- Үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүний хадгалах үйл ажиллагааг нэг бүрээр боловсруулж мөрдөөгүйгээс аюулгүй байдал алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх.
- Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнийг хамт хадгалж болохгүй бодис болон зориулалтын бус орчин, агуулахад хадгалснаас хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх.
- Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнийг хадгалах үйл ажиллагаа нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбай, ослын үед ажиллах арга хэмжээний төлөвлөгөөгүй ажилласнаас хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хохирол үүсэх.
- Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнтэй харьцаж ажиллах ажиллагсад нь зохих шатны сургалтад хамрагдаагүй, зохих мэдлэг дадлыг эзэмшээгүйгээс ажиллах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг зөрчих, хордох.
- Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүний агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд заасан болзошгүй аюул, ослын үед ашиглах багаж хэрэгсэл, материалыг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлээгүйгээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учрах.
- Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүн нь хэвийн нөхцөлд тогтвортой боловч өндөр температурт шатах, хүчтэй хүчлүүдтэй урвалд орвол аюултай бодис тул харьцах үедээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс асгарч алдагдах, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөл үзүүлэх зэрэг болно.

Хүснэгт 13. Хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдал, үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Мааш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
1	Үйлдвэрийн үндсэн болон туслах барилга байгууламжийн хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарах	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
2	Мэргэжилтэн, ажилтны чадваргүй байдал, хариуцлагагүй үйлдэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс ажлын байранд аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүн алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай		х			
		Ховор					
3	Үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүний хадгалах үйл ажиллагааг нэг бүрээр боловсруулж мөрдөөгүйгээс аюулгүй байдал алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй			х		
		Магадлал муутай					
		Ховор					
4	Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнийг хамт хадгалж болохгүй бодис болон зориулалтын бус орчин, агуулахад хадгалснаас хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
	Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнийг хадгалах үйл	Зайлиггүй					
		Боломжтой					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
5	ажиллагаа нь хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбай, ослын үед ажиллах арга хэмжээний төлөвлөгөөгүй ажилласнаас хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хохирол үүсэх	Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
6	Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнтэй харьцаж ажиллах ажиллагсад нь зохих шатны сургалтад хамрагдаагүй, зохих мэдлэг дадлыг эзэмшээгүйгээс ажиллах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг зөрчих, хордох	Зайлиггүй					
		Боломжтой			х		
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
7	Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүний агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд заасан болзошгүй аюул, ослын үед ашиглах багаж хэрэгсэл, материалыг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлээгүйгээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учрах	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй			х		
		Магадлал муутай					
		Ховор					
8	Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүн нь хэвийн нөхцөлд тогтвортой боловч өндөр температурт шатах, хүчтэй хүчлүүдтэй урвалд орвол аюултай бодис тул харьцах үедээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс асгарч алдагдах, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөл үзүүлэх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
НИЙТ			4	1	3		
ЭЗЛЭХ ХУВЬ (%)			50	12.5	37.5		
	ДҮГНЭЛТ	Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүний хадгалалт, ашиглалтаас хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн 62.5% нь бага, маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалын 50% нь ховор тохиолдохоор байна. Хариу					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
		нийт нөлөөллийн 37.5% нь нөлөөллийн эрчим цар хүрээгээр дунд гэсэн ангилалд орж байгаа бөгөөд тохиолдох магадлалаар нь авч үзвэл магадгүй болон боломжтой ангилалд орж байна. Учир нь тус байгууллага нь үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүн хадгалах үйл ажиллагааг нэг бүрээр боловсруулж мөрдөөгүйгээс аюулгүй байдал алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх, аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнтэй харьцаж ажиллах ажиллагсад нь зохих шатны сургалтад хамрагдаагүй, зохих мэдлэг дадлыг эзэмшээгүйгээс химийн бодистой харьцаж ажиллах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг зөрчих, хордох, химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд заасан болзошгүй аюул, ослын үед ашиглах багаж хэрэгсэл, материалыг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлээгүйгээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учрах эрсдэлтэй байгаа тул хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сайтар ханган ажиллах шаардлагатай. Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан тохиолдолд химийн бодисын хадгалалтаас хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх боломжтой байна.					

1.4 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

1.4.1. Байгаль хамгаалах ажлын зорилго, зорилт:

Хан Алтай төслийн 2025 оны байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөөг 2023 онд Грийн Ассесмент ХХК-ийн боловсруулсан “Товь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт орших “Хан Алтай ресурс” ХХК-ийн MV-021537 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хан-Алтайн алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах, исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах аргаар баяжуулах үйлдвэрийн төсөл”-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд тус төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг зорилго болгосон.

Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

- Уурхай болон түүнтэй холбогдолтой дэд бүтцийг хөгжүүлэхэд шаардлагатай талбайн газрын эвдрэл, эвдрэлийг багасгах;
- Төсөл хэрэгжилтийн явцад үүссэн хаягдал чулуулаг, овоолгыг үе шаттайгаар нөхөн сэргээх, техникийн нөхөн сэргээлт, хэлбэржүүлэлт дээр онцгой анхаарал тавьж ажиллах;
- Төсөл хэрэгжих орчны анхны төрх хэлбэрийг хадгалж, тэдгээрийн тогтвортой аюулгүй байдлыг хангах, уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн зорилтуудыг хэрэгжүүлэх;
- Урт хугацааны тогтвортой байдлыг бий болгохын тулд гадаргын хоосон орон зайг эцэслэн шийдэх, хэлбэржүүлэх;

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

- Уурхай болон бүтээгдэхүүн зөөх, тээвэрлэх замуудыг усаар чийглэх;
- Салхи ихтэй байгаа нөхцөлд хаягдлыг салхины чиглэлийн доод талд, хамгаалалт бүхий хэсэгт буулгах;
- Хаягдлын даланг аль болох хурдан хугацаанд нөхөн сэргээж, идэвхтэй хэсгийн талбайг багасгах;

Хөрсөн бүхэвчид үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

- Ажилчдын байранд нэгдсэн ариун цэврийн өрөө төлөвлөж барих шаардлагатай байгаа бөгөөд бохир ус нийлүүлэх цооног, орчны талбайг бетондох, хашлага хийж, бохир ус гадагш урсахааргүй болгож тохижуулах;
- Ахуйн бохир усыг ил задгай асгах, бохир усны цооног халих, бохир усыг доторлогоогүй цооногт хадгалах зэргээр хөрс бохирдуулахаас сэргийлэх;
- Олборлолт дууссаны дараа дээрх хэсгүүдийн ашиглагдсан талбайг хэлбэршүүлэх, тэгшлэх, үржил шимт хөрсөөр хучих зэргээр техникийн нөхөн сэргээлт хийх;

Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

- Тосгон ба ордыг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах далан байгуулах;
- Гүний худгийн эргэн тойронд ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож хашаажуулах;
- Төслийн хүчин чадалд тохирсон бохир ус цэвэрлэх байгууламж байгуулах, ашиглана.;

Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

- Бүтээн байгуулалт, хурдас чулуулгийн овоолгыг гүйцэтгэлийн үе шатуудаар тооцож, хүмүүсийн ажиллаж, амьдрах орчныг нөхөн сэргээхэд ашиглах шимт хөрсний овоолгыг нар, салхины нөлөөллөөс хамгаалж хадгалах;
- Шимт хөрсний овоолгыг био нэмэгдлээр (бууц, үртэс, био бордоо г.м) баяжуулна.;
- Шимт хөрсний овоолгыг ургамалжуулах (услах, үрлэх);

- Уурхайн хаалт, нөхөн сэргээлт, дахин ургамалжуулах үйл ажиллагааг технологийн дагуу хийж гүйцэтгэнэ.;
- Овоолгын талбар нэмэгдэх тусам ургамлан нөмрөгт алсуур нөлөөлж байгаа нөлөөллийн мониторинг дүнг тодорхой үе шаттайгаар хянан баталгаажуулна;

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

- Ан амьтны үхэж хорогдохоос сэргийлэхийн тулд уурхайн байгууламж руу ан амьтан орохоос хамгаалах арга хэмжээ авах, уурхайн ашиглагдсан талбайг нөхөн сэргээх болон бусад аливаа үйл ажиллагааны үед ан амьтны байршил нутагт нөлөөлөхгүй байхад илүүтэй анхаарах нь чухалчилна.
- Мөн ажиллагсад орон нутагт ан хийхийг хориглох, галт зэвсэг болон бусад зэвсэг хэрэгсэл байлгахыг хориглох,

Түүх соёлын дурсгалт зүйлст үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

- Замын барилгын ажлын үед соёлын үнэт зүйл тааралдвал, үүнийг Монгол Улсын Соёлын Өвийг Хамгаалах тухай хуулийн дагуу зохих газарт нь мэдэгдэнэ. Албан ёсны шийдвэр иртэл соёлын үнэт зүйлийг хөндөхгүй байна.
- Олборлолтын ажлын явцад түүх соёлын дурсгалт зүйл, үнэт өв илэрсэн тохиолдолд хамгаалалтын бүсийг тогтоох, талбайд ашигт малтмалын хайгуулын өрөм тавих, суваг шуудуу, нүх ухах, том техникээр дээгүүр нь явах зэргээр хөрсийг гэмтээж болохгүй. Хэрэв дээрх үйлдлүүдийг хийвэл, уг дурсгалууд гэмтэх эвдрэх аюул бий болно.

2025 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт нь Агаарын чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахыг зорин ажиллаж нэмэлтээр дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна.

1. Ил уурхайн тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтыг бууруулах, технологийн замын ачааллыг багасгах ажлын хүрээнд ил уурхайн бүсэд 4 сая/тн хүчин чадал бүхий MMD бутлуурын үйлдвэр, ил уурхайгаас нуруулдан уусгах байгууламж хүртэл технологийн зам дагуу 6.3 км урт LIVO туузан дамжуулга, конвейрийг ашиглалтад оруулж үйл ажиллагааг эхлүүлсэн.
2. Ил уурхайн замын тоосжилттой хэсгүүдэд тоосжилт бууруулах DUSTLOC plus бодисын туршилтын ажлыг ECO Soil LLC мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна.
3. Ил уурхайн технологийн замын усалгааг үр дүнтэй хийх зорилгоор ZOOMLION брэндийн 60 тн усны машин 1 ширхгийг нэмэгдүүлж тоосжилт бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.4.2. Хамрах хүрээ:

Хан Алтай төслийн MV-021537 лицензийн 6793.28 га талбайд явагдаж байгаа барилгын ажил, үндсэн олборлолтын үйл ажиллагаанаас гадна дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой бүхий л үйл ажиллагаанд хамаарна.

БҮЛЭГ ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн дэлгэрэнгүй

2.1.1. Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор зам усалгааг хуваарийн дагуу тогтмол хийх

2025 онд уурхайн технологийн болон дотоод замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгааны ажлыг батлагдсан хуваарийн дагуу тогтмол хэрэгжүүлж, 3 дугаар улирлын байдлаар зам усалгаанд **53,641.0 м³** ус ашигласан байна.

Усалгааны ажлыг 20 тонн багтаамжтай 3 усны машин болон шинээр 60 тонн багтаамжтай Zoomlion брэндийн усны машин ашиглан өдөр, шөнийн ээлжээр дулааны улиралд хийсэн бөгөөд хуурайшилт өндөртэй 5–9 дүгээр саруудад усны хэрэглээ хамгийн их байсан. (8,168–8,705 м³).


2024 онд зам талбайн усалгаанд 3 дугаар улирлын байдлаар 70,942.0 м³ ус ашигласан бол 2025 онд усны хэрэглээ 17,301.0 м³ буурсан үзүүлэлттэй байна.

Усны хэрэглээ буурсан нь дараах үр дүнтэй арга хэмжээнүүдтэй холбоотой гэж дүгнэв:


- 60 тонн багтаамжтай Zoomlion брэндийн шинэ усны машин худалдан авч ашигласнаар ус тээвэрлэлтийн үр ашиг сайжирсан,
- Ил уурхайгаас нуруулдан уусгах байгууламж хүртэл технологийн зам дагуу 6.3 км урт LIVO туузан дамжуулга, конвейрийг ашиглалтад оруулж үйл ажиллагааг эхлүүлсэн,
- Тоосжилт ихтэй хэсэгт зорилтот усалгаа хэрэгжүүлж, үр ашигтай ус хуваарилалт хийсэн.

Эдгээр арга хэмжээний үр дүнд уурхайн орчны агаарын тоосжилтын түвшин буурч, замын нөхцөл сайжирч, агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл буурсан.

График 1. Зам талбайн тоосжилт дарах зорилгоор ашигласан усны хэмжээ



Зураг 12. Уурхайн технологийн болон дотоод замын сүлжээ зураг



Зураг 13. Зам талбайн тоосжилт дарах арга хэмжээ



2.1.2. Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын сайжруулалт засвар, үйлчилгээг тогтмол хийх

Замаас үүсэх тоосжилтыг бууруулах, авто замын сайжруулалтын ажлын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

Замын засвар, сайжруулалт:

- Төслийн талбай доторх технологийн 13.1 км зам талбай, орон нутгийн Улцангийн даваа, Хангийн гол, Бигэр чиглэлийн замуудад засвар, сайжруулалтын ажлыг тухай бүр нь тогтмол хийсэн.
- Төслийн талбай доторх ашиглалтгүй болсон 2.2 км замыг хааж, техникийн нөхөн сэргээлт хийсэн.
- Замын сайжруулалт, засвар арчилгаанд Автогрейдер 1, Авто ачигч 2, Бульдозер 1, Индүү 2, Усны машин 1 тус тус ашиглан ажиллуулсан.

Замын тэмдэг тэмдэглэгээ:

- Төслийн талбай дотор болон орон нутгийн замуудад шинээр 65 ширхэг замын тэмдэг тэмдэглэгээг нэмэлтээр байрлуулж, зөөвөрлөхөд хялбар байдлаар бетонон суурьтай болгосон.
- Тээврийн хэрэгслийн зогсоолыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Техник засвар үйлчилгээний авто зогсоол, Уурхайн нэгдсэн агуулахын авто зогсоол, Хүнд машин механизмын авто зогсоолуудыг шинээр байгуулж шаардлагатай тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан.

Үерийн эвдэрсэн жалга, дүүргэлт:

- Үерийн улмаас эвдэрсэн жалга, авто замуудын нөхөн дүүргэлтийг хийж, шаардлагатай газруудад үерийн далан байгуулсан.

Хяналт шалгалт:

- Замын засвар, нөхөн сэргээлт, тэмдэг тэмдэглэгээний ажлын чанарт тогтмол хяналт шалгалт хийсэн.
- Хяналтын үр дүнд тоосжилт бууруулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах нэмэлт арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Төслийн талбайгаас Бигэр чиглэлийн 58 км авто замын сайжруулалт:

- Авто Ачигч 1, Авто Грейдер 2, Хөнгөн тэрэг 1 бүрэлдэхүүнтэй нийт 4 ажилтан өдөр шөнийн ээлжээр 6 өдөр ажиллаж 58 км замын сайжруулалт хийж орон нутагт хүлээлгэн өгсөн.

Үр дүн:

- Замын ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдал сайжирсан.
- Ашиглалтгүй болсон зам талбай хаагдсанаар эвдэрсэн газар эдгэрэх, байгалийн аясаар нөхөн сэргээгдэх боломж нөхцөл бүрдсэн.
- Жалга, дүүргэлтийн ажил хийгдсэнээр эвдэрсэн хэсгүүд нөхөн сэргээгдсэн.
- Замын тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлж хөдөлгөөний зохицуулалт сайжирсан.

Зураг 14. Төслийн талбай доторх технологийн 13.1 км зам талбайн арчилгаа

				
Төслийн талбайн зам сайжруулалт	Төслийн талбайн тэмдэг тэмдэглэгээ	Улцангийн давааны зам сайжруулалт	Тэмдэг тэмдэглэгээ парк талбайн сайжруулалт	Улцангийн давааны зам сайжруулалт

Зураг 15. Авто зогсоол, замын тэмдэг тэмдэглэгээ байгуулалт

				
Парк талбайн сайжруулалт /Уурхайн нэгдсэн агуулах/	Төслийн талбайн замын тэмдэгнүүдийг сууригтай болгосон	Тэмдэг тэмдэглэгээ парк талбайн сайжруулалт /Техник засвар үйлчилгээний хэлтэс/	Тэмдэг тэмдэглэгээ парк талбайн сайжруулалт /Уурхайн нэгдсэн агуулах/	Парк талбайн сайжруулалт /Уурхайн нэгдсэн агуулах/

Зураг 16. Зам Төслийн талбайгаас Бигэр чиглэлийн 58 км авто замын сайжруулалт

№	Техникийн төрөл	Парк дугаар	Фото зураг	Ажилласан хоног	Бүтээлтэй цаг	Сул зогсолт		Тайлбар	Хүн хүч
						Сул зогсолт	Засвар		
1	Авто Ачигч	WL-1431		6	45	0	0	Үерт эвдэрсэн жалга дүүргэлт материал татсан.	4
2	АвтоГрейдер	GR-5001		6	45	0	0	Зам сайжруулалт	
3	АвтоГрейдер	GR-501		6	45	0	0	Зам сайжруулалт	
3	Хөнгөн тэрэг	LV-103		6	45	0	0	Зам засвар сайжруулалт хяналт шалгалт	



2.1.3. Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор тээврийн хэрэгслийн хурдны дээд хязгаарыг 40км цаг-т тогтоож хяналт тавих

Тайлант онд 10 байршилд, 40 удаагийн давтамжтай нийт 590 тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хурд хэмжилтийн хяналтыг зохион байгуулсан. Хурд хэтрүүлсэн 5 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах арга хэмжээ авч, холбогдох жолооч нарыг давтан зааварчилгаанд хамруулсан байна.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Тээврийн хэрэгслийн хурдны дээд хязгаарыг 40 км/цаг-аар тогтоон мөрдүүлж байна.
- Хяналтыг сайжруулах зорилгоор замын дагуух 10 байршилд хурд хэмжилтийн шалгалтыг 40 удаагийн давтамжтайгаар зохион байгуулсан.
- Нийт 590 тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянаж, 7 хурд хэтрүүлсэн зөрчил илрүүлсэн.
- Зөрчил гаргасан жолооч нарт анхааруулга өгч, давтан зааварчилгаа, сургалтад хамруулсан.
- Хурд хэтрүүлсэн зөрчил, тоосжилтын түвшний уялдааг хянах зорилгоор усалгааны хуваарь, хөдөлгөөний ачааллын зохицуулалтыг хийсэн.

Хэрэглэсэн арга хэрэгсэл, зохион байгуулалт:

- Замын дагуух анхааруулах болон хурдны хязгаарын тэмдэг нэмэлтээр байршуулсан.
- Хурд хэмжилтийг аюулгүй ажиллагааны багтай хамтран хэрэгжүүлсэн.
- Хурд хэмжилтийн бүртгэлд тулгуурлан долоо хоног бүрийн хяналтын дүнг нэгтгэн тайлагнадаг

Үр дүн:

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний дэг журам сайжирч, хурд хэтрүүлсэн тоо өмнөх оноос буурсан.
- Тоосжилт багасаж, замын гадаргуугийн элэгдэл, эвдрэл багасгах нөхцөл бүрдэж байна.
- Хөдөлгөөний аюулгүй байдал дээшилж, ажилчдын эрүүл, аюулгүй орчныг хангах нөхцөл бүрдэж байна.

Зураг 17. Тээврийн хэрэгслийн хурд хэмжилтийн маягт, зөрчлийн хуудас

[illegible]

2.1.4. Уурхайн талбайд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслүүдийн яндангаас ялгарах хорт хийн хэмжээг хянах зорилгоор тээврийн хэрэгслийн улсын үзлэгт хамруулах

Уурхайн талбайд ашиглагдаж буй үндсэн болон гэрээт компаниудын тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдал, утаа ялгарал, агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл, хуулийн нийцлийг хангах зорилгоор улсын үзлэг, оношилгоог төслийн талбайд хоёр удаа зохион байгуулж тээврийн хэрэгслүүдийг бүрэн хамруулсан.

Хаврын ээлжит улсын үзлэг (2025.02.12–13)

- Говь-Алтай аймгийн Авто тээврийн төвтэй хамтран уурхайн талбайд улсын үзлэг, оношилгоог зохион байгуулсан.
- Үзлэгт:
 - “Хан Алтай Ресурс” ХХК-ийн 28 техник,
 - Гэрээт компаниудын 46 техник,
 - Нийт 74 техник, тээврийн хэрэгсэл хамрагдсан.
- Үзлэгийн хүрээнд дараах үзүүлэлтүүдийг шалгасан:
 - Дугуйн хээ, элэгдэл
 - Хөргүүрийн шингэний хүйтэнд тэсвэртэй байдал
 - Яндангийн хорт утааны хэмжилт
 - Дугуйн хийн даралт
 - Их гэрлийн тусгал, тоормосны ажиллагаа
 - Аюулгүй ажиллагааны нэмэлт тоноглол
 - Хурдны хайрцгийн ажиллагаа
- Илэрсэн жижиг зөрчлүүдийг газар дээр нь арилгаж, шаардлагатай техникийг засвар үйлчилгээ хийлгэх хүртэл түр зогсоосон.
- Үзлэгийн дүнгээр тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдал 96%, улсын стандартын шаардлагад нийцсэн байна.

Намрын ээлжит улсын үзлэг (2025.09.11)

- Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум дахь Авто тээврийн төвийн үзлэг хяналтын инженер, улсын байцаагч нарын 2 хүний бүрэлдэхүүнтэй баг уурхайн талбайд намрын ээлжит улсын үзлэг, оношилгоог зохион байгуулсан.
- Үзлэгээр дараах мэдээллийг шалгасан:
 - Тээврийн хэрэгслийн улсын бүртгэл, үзлэгийн хүчинтэй байдал
 - Албан журмын даатгал, татвар, торгуулийн үлдэгдэл
 - Техникийн бэлэн байдал, утаа ялгарал
- Үзлэгийн дүн:

- “Хан Алтай Ресурс” ХХК-ийн 6 тээврийн хэрэгсэл бүрэн хамрагдсан.
- Гэрээт 8 байгууллагын 15 тээврийн хэрэгслээс 9 нь үзлэгт хамрагдаж, 6 нь талбайгаас буусан.
- Илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, шаардлагатай техникүүдийг түр ашиглахгүй байхаар шийдвэрлэсэн.

Нэгдсэн үр дүн (2025 он)

Үзлэгийн төрөл	Хамрагдсан байгууллага	Хамрагдсан техник (тоо)	Гүйцэтгэл
2025.02.12 хаврын үзлэг	“Хан Алтай ресурс” ХХК + гэрээт байгууллагууд	74	96%
2025.09.11 намрын үзлэг	“Хан Алтай ресурс” ХХК + гэрээт байгууллагууд	21	72% (нийлбэр дундаж)

Нийт хамрагдалт:

- 2025 онд нийт **95 тээврийн хэрэгсэл улсын үзлэг, оношилгоонд хамрагдсан.**
- Үүнээс “Хан Алтай ресурс” ХХК-ийн техникийн бүрэн хамрагдалт **100%**, гэрээт байгууллагуудын хамрагдалт **72%-тай** гарсан.

Үр дүн:

- Үндсэн болон гэрээт байгууллагуудын тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн ажиллагаа, техникийн бэлэн байдал сайжирсан.
- Улсын үзлэгийг уурхайн талбайд зохион байгуулснаар ажлын тасалдалгүй, хяналтын үр ашиг дээшилж, хамтын ажиллагаа сайжирсан.

Зураг 18. Тээврийн хэрэгслийн үзлэг зохион байгуулсан байршил



Зураг 19. Тээврийн хэрэгслийн улсын үзлэг, оношилгоонд шалгуулж буй байдал.



2.1.5. Химийн бодисыг шатах, гал авалцах эх үүсвэр болон хамт хадгалж болохгүй бодисуудыг тусад нь хадгалах

Уурхайн талбайн химийн бодисын агуулах нь MNS 6458:2014 “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага” стандартад тавигдах шаардлагыг бүрэн хангаж байгаа бөгөөд энэ тухай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 018/87 тоот дүгнэлт 2022.09.15-нд гарсан.

Химийн бодис тус бүрийн хор аюулын лавлах мэдээлэл (MSDS) боловсруулж, зориулалтын сав баглаа боодол, стандартын дагуу монгол хэл дээр хаяг, шошго байрлуулан хадгалалт, ашиглалтыг явуулж байна. Химийн бодисын орлого, зарлагын бүртгэлийг сар бүр хөтөлдөг бөгөөд 2025 онд нийт 37 нэр төрлийн 756.8 тонн химийн бодис ашигласан байна.

Хүснэгт 14. “Хан Алтай” төслийн үйлдвэрлэл, лабораторийн зориулалтаар 2025 онд ашигласан химийн бодисын мэдээлэл

№	Химийн бодисын нэр	Химийн томъёо	Ашиглалтын зориулалт
1.	Натрийн цианид	NaCN	Үйлдвэр
2.	Натрийн хлорид	NaCl	Үйлдвэр
3.	Бура	Na ₂ B ₄ O ₇	Үйлдвэр
4.	Калийн нитрат	KNO ₃	Үйлдвэр
5.	Сода	Na ₂ CO ₃	Үйлдвэр
6.	Флакс		Үйлдвэр
7.	Азотын хүчил	HNO ₃	Үйлдвэр
8.	Давсны хүчил	HCl	Үйлдвэр
9.	Антискалант		Үйлдвэр
10.	Натрийн шүлт	NaOH	Үйлдвэр
11.	Идэвхжүүлсэн нүүрс		Үйлдвэр
12.	Азотын хүчил лаб	HNO ₃	Лаборатори
13.	Давсны хүчил лаб	HCl	Лаборатори
14.	Мөнгөний нитрат	AgNO ₃	Лаборатори
15.	Бромт устөрөгч	HBr	Лаборатори

16.	Аммиак	NH_3	Лаборатори
17.	Фенолфталеин	$\text{C}_{20}\text{H}_{14}\text{O}_4$	Лаборатори
18.	Метилоранж	$\text{C}_{14}\text{H}_{14}\text{N}_3\text{NaO}_3\text{S}$	Лаборатори
19.	Лемоны хүчил	$\text{C}_6\text{H}_8\text{O}_7$	Лаборатори
20.	Ацетилен	C_2H_2	Лаборатори
21.	Буффер уусмал 4.01		Лаборатори
22.	Буффер уусмал 7.01		Лаборатори
23.	Буффер уусмал 10.01		Лаборатори
24.	Этанол	$\text{C}_2\text{H}_5\text{OH}$	Лаборатори
25.	Хүхрийн хүчил	H_2SO_4	Лаборатори
26.	Роданин	$\text{C}_3\text{H}_3\text{NOS}_2$	Лаборатори
27.	Ацетон	$\text{C}_3\text{H}_6\text{O}$	Лаборатори
28.	Алтны 1000гр/тн стандарт уусмал		Лаборатори
29.	Алтны 100гр/тн стандарт уусмал		Лаборатори
30.	Мөнгөний 1000 гр/тн стандарт уусмал		Лаборатори
31.	Мөнгөний 100 гр/тн стандарт уусмал		Лаборатори
32.	Зэсийн 1000гр/тн стандарт уусмал		Лаборатори

Мөн “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 13.7 дахь хэсэгт заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд ашиглагдаж буй бодисын ашиглалт, зарцуулалтын тайланг холбогдох төрийн байгууллагуудад тогтмол хүргүүлж, хууль, стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Зураг 20. Химийн бодисын агуулахын тасалгаа



Зураг 21. Химийн бодисын хадгалалт бүртгэл тооллого



2.1.6. Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах

Ажилчдын эрүүл мэндийг уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, химийн бодисын нөлөөллөөс хамгаалах, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлж байна:

1. Хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр хангах:

- “Хор саармагжуулах бүтээгдэхүүн олгох журмын I хавсралт”-ын дагуу тухайн онд нийт 7 нэр төрлийн бүтээгдэхүүн (Артишок, Увидасу-дархлаа дэмжих, хар саримсны ханд, хор саармагжуулах, Лагшин ундаа, Аньсны шүүс) нийт 90,936 ширхгийг давхардсан тоогоор 1,823 ажилтанд олгож, бүртгэлээр баталгаажуулсан.

2. Амьсгал хамгаалах хэрэгслийн тохироо:

- Уурхайн үйл ажиллагааны үеэр үүсэх тоосонд өртөж ажилладаг ажилчдад ажлын 8 цагийн статик өртөлтийн хэмжилт-ийг стандартын дагуу хийж, өртөлтийн эрсдэлийн түвшнийг тогтоосон.
- Өртөлтийн түвшин тус бүрд тохирсон амьсгал хамгаалах хэрэгслийн тохирооны сорил (fit test)-ыг “Хэлт Инспекшин ХХК”-тай хамтран амжилттай зохион байгуулсан.
- Энэхүү сорилд нийт 71 ажилтан хамрагдаж, MNS 6654:2017 стандартын дагуу хувь хүнд тохирсон амьсгал хамгаалах баг-ийг сонгон хэрэглүүлсэн.

3. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл сайжруулах арга хэмжээ:

- Тоосны өртөлтийн дамжих замд чиглэсэн хэсэгт агааржуулалтын сорох төхөөрөмж-ийг суурилуулж, агаарыг тогтмол соруулан гадагшлуулан тоосжилтыг бууруулсан.

Үр дүн:

- Ажилчдын эрүүл мэндийн эрсдэл буурч, хөдөлмөрийн нөхцөл сайжирсан.
- Тоосжилт, химийн бодисын ялгарал хяналт сайжирч, агаарын чанар дээшилсэн.
- Энэхүү арга хэмжээ нь эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцөлийг тасралтгүй сайжруулах үндсэн зорилготойгоор тогтмол хэрэгжиж байна.

Зураг 22. Хор саармагжуулах бүтээгдэхүүн



Зураг 23. Тоосноос хамгаалах хэрэгслийн сорил



2.1.7. Хүлэмжийн хийн тооллого судалгаа хийх

Хан Алтай төслийн 2024 оны Хүлэмжийн хийн тооллого судалгааг ISO 14064-1:2018 буюу Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийг тооцоолох, тайлагнах тухай зааварчилсан стандарт болон Хүлэмжийн хийн протоколоор (GHG protocol) боловсруулсан аргачлалын дагуу, нийт ялгаруулалтыг шууд болон шууд бус ялгаруулалт (Scope 1.2)-ын хүрээнд тооцоолсон.

2024 онд төслийн үйл ажиллагаанаас ялгаруулсан ялгаруулсан нийт хүлэмжийн хий **38,875.51 CO2 экв.в. тонн**:

- **Scope 1.** Хүлэмжийн хийн шууд ялгарал 38,526.44 CO2 экв.в. тонн буюу нийт ялгарлын 99.10%
- Хүлэмжийн хийн шингээлт 31,57 CO2 экв.в. тонн буюу нийт ялгарлын 0,08%
- **Scope 2.** Хүлэмжийн хийн шууд бус ялгарал (АУЭХС-ийн Цахилгаан эрчим хүчний ХХЯ) 380.64 экв.в. тонн буюу нийт ялгарлын 0.98%

ТАЙЛАГНАЖ БАЙГУУЛЛАГА		БУЙ	ХАН АЛТАЙ РЕСУРС ХХК	
Тайлант хугацаа			2024 оны 1-12-р сар	
Тооллогын хамрах хүрээ			Scope 1 , Хүлэмжийн хийн шууд ялгарал ба шингээлт	
			Scope 2 , Хүлэмжийн хийн шууд бус ялгарал	
			Scope 3 , Хүлэмжийн хийн шууд бус ялгарал- Категори 3,5 болон 7	
Хүлэмжийн хийн ялгарал ба шингээлт			CO2-экв. [тонн]	
ДҮН				
Scope			CO2 экв.в. нийт дүн [тн]	Нийт ХХЯ- дээлэх хувь
Scope 1	Хүлэмжийн хийн шууд ялгарал ба шингээлт		38,073.59	81.11%
1-1	Түлш шатахууны ХХЯ		38,042.02	81.04%
1-2	Хүлэмжийн хийн шингээлт- Мод		(18.45)	0.04%
1-3	Хүлэмжийн хийн шингээлт- Ургамлан бүрхэвч бүхий талбай		(13.12)	0.03%
Scope 2	Хүлэмжийн хийн шууд бус ялгарал		380.64	0.81%
2-1	АУЭХС-ийн Цахилгаан эрчим хүчний ХХЯ		380.64	0.81%
Scope 3	Хүлэмжийн хийн шууд бус ялгарал		8,488.83	18.08%


3-2	Түлш, эрчим хүчтэй холбоотой үйл ажиллагаа (Кат 3)	5,811.63	12.38%
3-3	Үйл ажиллагаанаас үүдэлтэй хог хаягдал (Кат 5)	1,796.56	3.83%
3-4	Ажилтнуудын хөдөлгөөн (Кат 7)	880.64	1.88%

Хүлэмжийн хийн шууд ялгарал ба шингээлт (Score 1 тооцоолол)

“Хан Алтай Ресурс” ХХК-ийн хүлэмжийн хийн шууд ялгарал буюу Score 1-д компанийн 2024 оны шууд үйл ажиллагаандаа шатааж хэрэглэсэн түлш, шатахууны хэрэглээний мэдээллийг цуглуулан авч тооцоолоход нийт **38,042.02 CO2 экв.тонн** хүлэмжийн хийн ялгарлыг бий болгосон байна. Халаалтын зуухны түлш шаталтаас (Боловсруулах үйлдвэр, Өргөө кемп, ТЗҮХ-ийн халаах зуух) ялгарсан ХХЯ 18,745.25 CO2 экв.тонн буюу нийт хүлэмжийн хийн шууд ялгаруулалтын 49% эзэлж байгаа бөгөөд 2023 он буюу суурь төвшнөөс 2,6 дахин нэмэгдсэн. Энэ нь 2024 онд үйлдвэрлэл, олборлолтын үйл ажиллагаа жигдэрч, эрчимжсэн буюу олборлон, нуруулдсан хүдрийн хэмжээ нэмэгдсэнээр тайлбарлагдах юм.

- Ахуйн зуухны түлш шаталтаас үүсэх буюу кемп, гэр, зөөврийн ажлын байрны халаалтаас (Дулааны эрчим хүч) үүссэн ХХЯ 2,687.68 CO2 экв.тонн буюу нийт (Score 1) шууд ялгарлын 7.1% эзэлж байгаа бөгөөд суурь түвшний үзүүлэлтээс 1.3 дахин буурсан нь 2024 онд 2 давхар, 128 өрөө ажилчдын орон сууцыг ашиглалтад оруулж 894 ажилтныг байрлуулж, гэр сууцны тоог 172-оос 132 болж бууруулсан холбоотой.
- Өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслүүдэд буюу байгууллага өөрөө хариуцан гүйцэтгэдэг хүн тээвэр, ачаа тээвэр, тусгай зориулалтын ажил үйлчилгээний үйл ажиллагаанаас ялгарсан ХХЯ 14,628.88 CO2 экв.тонн буюу нийт шууд ялгарлын 38% эзэлж байгаа бөгөөд өмнөх оныхоос 1,3 дахин үзүүлэл юм.
- Харин тайлант онд томоохон эрчим хүчний хэрэглэгчдийг АУЭХС-д холбогдсонтой холбоотойгоор генератораар эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагаанаас үүссэн ХХЯ 1,980.2 CO2 экв.тонн болж буурсан. Энэ нь нийт шууд ялгарлын 5% эзлэх бөгөөд өмнө оныхоос 1,3 дахин буурсан үзүүлэлт юм.

График 2. Хүлэмжийн хийн шууд ялгарал 2023,2024 оны харьцуулалт



Хүлэмжийн хийн шууд бус ялгарал ба шингээлт (Score 2 тооцоолол)

Хүлэмжийн хийн шууд бус ялгарал буюу Score 2-ыг тооцоололд гаднаас худалдан авч хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний мэдээлэлд үндэслэн тооцоолсон. 2024 онд АУЭХС-с нийт

5,437,708.7 кВт.ц эрчим хүчийг авч ашигласан бөгөөд нийт 380.64 тн.CO2-экв ХХЯ-ыг бий болгосон байна.


Энэ нь 2023 он буюу өмнө жилийнхээс 4,6 дахин нэмэгдсэн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтийн гол шалтгаан нь тус онд Өргөө кемп, тэсрэх материалын агуулах, цэвэр ус цэвэршүүлэх, нөөцлөх байгууламж, үйлдвэрийн оффис, лаборатори, бетон зуурмагийн үйлдвэр зэрэг томоохон эрчим хүчний хэрэглэгчдийг цахилгаан дамжуулах агаарын шугамтай холбосонтой холбоотой.

Хан Алтай төсөл нь эрчим хүчний хосолсон эх үүсвэртэй буюу тайлант онд ашигласан нийт 7,109,242.85 кВт.ц эрчим хүчний 76.49% нь АУЭХС-ээс, 23.51%-г GENSET дизель генератораас нийлүүлэгдсэн. АУЭХС-ээс ашигласан 5,437,708.65 кВт.ц эрчим хүчид ноогдох ХХЯ нь 380.64 тн.CO2-экв (Score 2), харин дизель генератораар үйлдвэрлэсэн 1,671,534.20 кВт.ц эрчим хүчид ноогдох ХХЯ нь 1,599.75 тн.CO2-экв (Score 1) байгаа юм. Өөрөөр хэлбэл цахилгаан станцад 1 кВт.ц эрчим хүч үйлдвэрлэхэд ялгарсан ХХ хэмжээ нь дизель генераторт үйлдвэрлэгдсэн эрчим хүчний ялгаруулах хэмжээнээс 13,7 дахин бага, мөн компанийн шууд ялгаралд тооцогдохгүй давуу талтай гэсэн үг юм.

Хүлэмжийн хийн шууд бус ялгарал (Score 3 хамрах хүрээний зарим тооцоолол)

2024 онд төслийн туслан гүйцэтгэгч компаниас худалдан авсан ажил үйлчилгээ, тээвэрлэлт, генераторын хэрэглээ болон хог хаягдал, ажилтнуудын хөдөлгөөнөөс үүссэн шууд бус ялгарал нийт 8,488.83 тн.CO2-экв бөгөөд 2023 оны суурь түвшний үзүүлэлт болох 14421.72 тн.CO2-экв хэмжээнээс буурсан үзүүлэлттэй байна.

График 3. Туслан гүйцэтгэгч компаниудын тули шатахууны хэрэглээнээс үүссэн ХХЯ 2023,2024 оны харьцуулалт



Дүнэлт: Хан алтай төслийн 2023 оны уулын ажлын тайланд тусгагдсан нийт үйлдвэрлэсэн алтны хэмжээ ба түүнд ногдох хүлэмжийн хийн ялгаруулалт (Score 1, 2-оор 24,276.68 тонн CO₂-е) харьцуулхад нэг килограмм алт үйлдвэрлэлээс ялгарсан ХХЯ 19.08 тонн CO₂-е байна. Харин 2024 оны тооцооллоор нэг килограмм алт үйлдвэрлэлээс ялгарсан ХХЯ 22 тонн CO₂-е болж өссөн байна.

2.2. Гадаргын болон газрын доорх усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2.2.1. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ус ашиглахдаа үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны батлагдсан нөөц болон усны боломжит нөөцөөс хэтрүүлэн ашиглахгүй байх.

Төслийн 2025 оны үйл ажиллагааны хүрээнд ус ашиглалтыг “Усны тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.11, 29.1 заалтуудын дагуу холбогдох зөвшөөрлийг төрийн байгууллагуудаас авч гэрээ байгуулан ажилласан. Үүнд:

- Ус ашиглуулах дүгнэлт: Усны газрын 2025 оны 04 сарын 02-ны өдрийн Е-2501-000329 дугаартай дүгнэлт.
- Ус ашиглах зөвшөөрөл: Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргааны даргын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/09 тушаал.
- Ус ашиглах гэрээ: 2025 оны 05-р сарын 26-ны өдрийн 03 дугаартай гэрээ

Ус авах эх үүсвэр:

- Төлөвлөсөн 10 гүний цооногоос ус авах бөгөөд 2025 онд нийт 5 цооногоос унд ахуй болон үйлдвэрлэлийн усан хангамжийг авч ашигласан.


Ашигласан усны хэмжээ (2025 онд):

- Унд ахуй: 17,043.0 м³
- Үйлдвэрлэл: 425,451.0 м³

Бүртгэл, хяналт:

- Унд ахуй болон үйлдвэрлэлд ашигласан усны хэмжээг сар тутамд бүртгэж, улирал тутамд Есөнбулаг сумын байгаль орчны тасгаар төлбөрийн ногдуулалтыг газар дээр нь хийлгүүлж байна.

График 4. Ус ашиглалт



Ашиглалтын худгуудын зориулалт:

- ГХ-1 – Унд ахуйн ус, ногоон байгууламж
- ГХ-2 – Унд ахуйн ус, ногоон байгууламж
- ХЦ-04 – Зам талбайн тоосжилт дарах
- Усан хангамж 3 – Ашигт малтмал олборлолт, зам талбайн тоосжилт, дулаан хангамж
- Усан хангамж 4 – Ашигт малтмал олборлолт
- Усан хангамж 5 – Ашигт малтмал олборлолт

Ус ашиглах гэрээгээр нийт 7 төрлийн зориулалтаар **484,587.1 м³** ус ашиглахаар баталгаажуулсан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын байдлаар гүний худгуудаас 6 төрлийн зориулалтаар унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар нийт **417,351.0 м³** ус авч ашигласан байна.

Зураг 24. Ус ашиглуулах дүгнэлт, зөвшигөөрөл, гэрээ

[illegible]

Зураг 25. Усны төлбөр ногдуулалт Улирал 1, 2, 3

2716 тегн/м² ± 0,3 ± 15% = 122,22 тегн Усны талбар: 8163м² ± 122,22 тегн/м² = 831,621.88 төгрөгийг Говь-Алтай аймгийн Баянхонгор сумын Төрийн сан Баяны уулы талбарын 1000000946 тоот дэвсгэрт талбаруулахаар илээхийг. НОГДУУЛАХ ХЯАМСАН БАЙГАЛЬ ХАМГААЛУУЧ <i>Б.Сүхбаатар</i> Э.ЭНХБААТАР ХЯМАСАН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХҮҮЛЭЭЛЭН УЛСЫН БАЙЦАЛЧ <i>Б.Сүхбаатар</i> Э.ЭНХБААТАР	Догол, дэвсгэртэй, 1434 м²-ыг ашигласан Баянхонгор сумын Төрийн сан Баяны уулы талбарын 1000000946 тоот дэвсгэрт талбаруулахаар илээхийг. 2716 тегн/м² - Эрдэс хурд-Баянхонгор сумын сан хөвдөр талбарын талбар дээрх урмы багасган, үрхэн засахыг суурь үнэлгээ. 0.15 - Баянхонгор сумын талбарын үндэслэлээр талбар дээрх урмы багасган талбарыг илээхийг. 15% - Эрдэсний Газрын 2015 оны 328 дугаар тогтоолын дагуу багасган урмы нэмэгдүүлсний талбарын 0.4 хэсэг урмы багасган. 2716 ± 0.15 ± 15% = 81.11 Усны талбар: 5,635 м² ± 81.11 тегн/м² = 36,803.85 тегн Усны талбар: 16,167.5 тегн ± 83,803.85 тегн = 110,171.45 төгрөгийг Говь-Алтай аймгийн Төрийн сан Баяны уулы талбарын 1000000946 тоот дэвсгэрт талбаруулахаар илээхийг өгнө. НОГДУУЛАХ ХЯАМСАН БАЙГАЛЬ ХАМГААЛУУЧ <i>Б.Сүхбаатар</i> Э.ЭНХБААТАР ХЯМАСАН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХҮҮЛЭЭЛЭН УЛСЫН БАЙЦАЛЧ <i>Б.Сүхбаатар</i> Э.ЭНХБААТАР	НОГДУУЛАХ ХЯАМСАН БАЙГАЛЬ ХАМГААЛУУЧ <i>Б.Сүхбаатар</i> Э.ЭНХБААТАР ХЯМАСАН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХҮҮЛЭЭЛЭН УЛСЫН БАЙЦАЛЧ <i>Б.Сүхбаатар</i> Э.ЭНХБААТАР
2025 оны 1-р дугаар улиралд ашигласан усны талбар 1. Ургамын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нийт 139,832,089.33 төгрөгийг Говь-Алтай аймгийн Төрийн сан Баяны уулы талбарын 1000000946 тоот дэвсгэрт 2. Үнд зүйлс нийт 786,875.58 төгрөгийг Говь-Алтай аймгийн Баянхонгор сумын Төрийн сан Баяны уулы талбарын 1000000946 тоот дэвсгэрт	2025 оны 2-р дугаар улиралд ашигласан усны талбар 1. Ургамын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нийт 283,889,832.46 төгрөгийг Говь-Алтай аймгийн Төрийн сан Баяны уулы талбарын 1000000946 тоот дэвсгэрт 2. Үнд зүйлс нийт 726,724.34 төгрөгийг Говь-Алтай аймгийн Баянхонгор сумын Төрийн сан Баяны уулы талбарын 1000000946 тоот дэвсгэрт	2025 оны 3-р дугаар улиралд ашигласан усны талбар 1. Ургамын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нийт 226,213,838.85 төгрөгийг Говь-Алтай аймгийн Төрийн сан Баяны уулы талбарын 1000000946 тоот дэвсгэрт 2. Үнд зүйлс нийт 715,842.38 төгрөгийг Говь-Алтай аймгийн Баянхонгор сумын Төрийн сан Баяны уулы талбарын 1000000946 тоот дэвсгэрт



2.2.2. Шинээр ашиглах худгуудад тоолуур суурилуулах, ашиглагдаж байгаа худгуудын тоолуурын бүрэн бүтэн байдлыг хангах

Төслийн 2025 оны үйл ажиллагааны хүрээнд усны хэрэглээг нарийвчлан хянах зорилгоор тоолуурын баталгаажуулалт дууссан ГХ-03 худгийн тоолуурын баталгаажуулалт хийлгэсэн.

Гүний худаг 3-т суурилуулсан усны тоолуур

- Байршил: Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Наран баг, Бөөрийн ам, 46°2'51.61" N, 96°54'13.08" E
- Тусгай зөвшөөрөл: MV-021537
- Тоолуурын загвар: MFE600, хэмжих хязгаар: 310 м³/ц, голч: 125 мм, дугаар: № 24051010
- Баталгаажуулалт: Стандарт хэмжил зүйн газрын 2025.06.10-ны өдрийн № ЭУ 248447 дугаартай гэрчилгээ, хүчинтэй хугацаа: 2027.06.10
- Суурилуулсан, битүүмжилсэн: №018 лацаар
- Хяналт: Есөнбулаг сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч Э.Энхбаатар, байгаль хамгаалагч Э.Няндагсүрэн, Хан Алтай ресурс ХХК-ийн Байгаль орчны зохицуулагч П.Сайхансанаа нар байлцсан
- Тоолуурын ашиглалт эхэлсэн үеийн заалт: 00002
- Суурилуулалт хийгдсэн журам: Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2013.05.16-ны өдрийн А-156 дугаар “Ус ашиглалт хэрэглээг тоолууржуулах журам”-ын дагуу

Зураг 26. Шугам хоолойнуудад шинээр суурилуулсан тоолуур



Хүснэгт 15. 2025 онд ашигласан худгууд, тоолууруудын стандарт хэмжээ зүйн гэрчилгээ

№	Нэр	Дугаар/Код	Баталгаажуулалт дуусах огноо	Гэрчилгээний зураг	Хэмжих хэрэгслийн зураг
1	Ус хангамж худаг-3 тоолуур	MFF-600	2027.06.10		
2	Ус хангамж худаг-4 тоолуур	MFF-600-125	2026.03.01		
3	Ус хангамж худаг-5 тоолуур	MFF-600-125	2026.03.01		
4	Гүний худаг -1 тоолуур	MVT 2200-50	2026.07.08		
5	Гүний худаг -2 тоолуур	MVT 2200-50	8/1/2026		
6	ХЦ-04 тоолуур	LXLC-80	2026.09.13		

2.2.3. Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжаас гарах саарал усыг шинжилгээнд хамруулж стандарт шаардлага хангасан тохиолдолд ногоон байгууламж, замын усалгаанд эргүүлэн ашиглах


Ажилчдын орон сууцны ахуйн бохир усны менежментийг сайжруулах, саарал усыг эргүүлэн ашиглах зорилгоор 97% хүртэл цэвэршүүлэх чадвартай MBR (Membrane Bioreactor) технологи

бүхий бохир ус цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулсан. Саарал усны дээжийг байгууламжийн хамгийн сүүлийн гаралтын хэсгээс авч MNS 4943:2015 стандартын дагуу улирал тутам шинжлүүлж байна.

Тус тоног төхөөрөмж нь ХБНГУ-ын Busse MF фирмийн мембран биореакторын технологи бүхий ахуйн бохир усыг цэвэрлэх төхөөрөмж бөгөөд дараах давуу талуудтай:

- Бохир усыг өндөр түвшинд (97%) цэвэршүүлнэ
- Байгаль орчинд сөрөг нөлөөгүй
- Өвчин үүсгэгч нян бактериудыг микробиологийн аргаар устгана
- Олон улсын болон дотоодын стандартыг бүрэн хангасан
- Монгол орны эрс тэс уур амьсгалд бүрэн тохирсон

Зураг 27. Бохир ус цэвэршүүлэх байгууламжын бүтээн байгуулалт



Хаягдал усны шинжилгээ:

Цэвэрлэх байгууламжийн гаралтын хэсгээс MNS стандартын дагуу дээж авч, Усны газрын лабораторид шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний үр дүнгээс үзвэл:

- Химийн болон биологийн хэрэгцээт хүчилтөрөгч (XXX, BXX) стандартын зөвшөөрөгдсөн хэмжээг давсан
- Хүнд металл болон бактериологийн үзүүлэлтүүд ямар нэгэн бохирдолгүй гарсан

Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, умбуур бодис, химийн хэрэгцээт хүчилтөрөгч зэрэг үзүүлэлтүүд стандартын зөвшөөрөх хэмжээнээс давсан үзүүлэлттэй гарсан тул саарал усыг дахин ашиглаж эхлээгүй. Харин бусад үзүүлэлтүүд болох рН, аммони, хлорид, сульфат, нитрит, нитратын үзүүлэлтүүд стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа бөгөөд саарал усны чанарыг стандартын

хэмжээнд хүргэх зорилгоор 2026 онд цэвэршүүлэх байгууламжид өргөтгөл хийж, сайжруулах ажлуудыг авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Зураг 28. Бохир усны шинжилгээний хариу

МОНГОЛ УСНЫ
ЗАСГИЙН ГАЗАР

УСНЫ ХЯНАЛТЫН ТӨВ ЛАБОРАТОРИ

Төрийн байрлал: Баянхонгор, 3 хаяг,
Төрийн байгуулалтын үйлчилгээний газар

ТЛ 092
MNS ISO 17025

СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС /Test of result/

Заяагчийн нэр /Customer name/ "Эко Эстимейт" ХХК			
Дээжний дугаар /Test number/	Дээжний хаг, байршил /Sample location/		Уст шалын төрөл /Type of water/
№ 293	Говь-Алтай аймаг, Баянхонгор сум, Цэвэрлэх байгууламжийн гаралт		Бохир ус
Дээжний тоо, хэмжээ /Quantity of the sample/	Дээж хураан авсан өгнөө /Date receipt/	Шинжилсэн өгнөө /Analysis date/	Техникийн шаардлага /Technical requirements/ MNS 4943:2015
1.5л / 1.5L /	2025.02.25	2025.03.13	Шинжилгээний аргын стандарт /Test method/ MNS ISO 11895:2011 /OP/

№	Үзүүлэлт /Parameter/	ЗДХ /Technical specification/ MNS	Үр дүн /Test result/
1	Магний (Mg) мг/л /Magnesium, Mg, mg/L/	<0.5	<0.005
2	Никель (Ni) мг/л /Nickel, Ni, mg/L/	<0.2	<0.005
3	Эх (Cu) мг/л /Copper, Cu, mg/L/	<1.0	0.149
4	Кадмий (Cd) мг/л /Cadmium, Cd, mg/L/	<0.03	0.0007
5	Кобальт (Co) мг/л /Cobalt, Co, mg/L/	<0.02	<0.005
6	Хар тугалга Pb мг/л /Lead, Pb, mg/L/	<0.1	0.0215
7	Цайр (Zn) мг/л /Zinc, Zn, mg/L/	<3.0	0.0035
8	Нийт төмөр (Fe) мг/л /Iron, Fe, mg/L/	<1.0	<0.005
9	Баксит (Bi) мг/л /Bismuth, Bi, mg/L/	-	0.0544
10	Молибден (Mo) мг/л /Molybdenum, Mo, mg/L/	<0.5	<0.005
11	Рубидий (Rb) мг/л /Rubidium, Rb, mg/L/	-	<0.005
12	Толуур (Te) мг/л /Tellurium, Te, mg/L/	-	<0.005
13	Селен (Se) мг/л /Selenium, Se, mg/L/	<0.02	<0.005

Шинжилгээ гүйцэтгэсэн /Test performed by/

Хянасан /Approved/

Хянасан /Approved/

Лабораторийн эрхлэгч /Head of laboratory/

Хуудас/1

МОНГОЛ УСНЫ
ЗАСГИЙН ГАЗАР

УСНЫ ХЯНАЛТЫН ТӨВ ЛАБОРАТОРИ

Төрийн байрлал: Баянхонгор, 3 хаяг,
Төрийн байгуулалтын үйлчилгээний газар

ТЛ 092
MNS ISO 17025

СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС /Test of result/

Заяагчийн нэр /Customer name/ "Эко Эстимейт" ХХК			
Шинжилгээний төдөөрлөлийн түрлийн төрөл /Analysis type/	Дээжний дугаар /Sample number/	Дээжний хаг, байршил /Sample location/	Уст шалын төрөл /Type of water/
Бохир усны хяналтын лаборатори	№ 293	Говь-Алтай аймаг, Баянхонгор сум, Цэвэрлэх байгууламжийн гаралт	Бохир ус

Дээжний хэмжээ /Quantity of sample/	Дээж хураан авсан өгнөө /Receiving date/	Шинжилсэн өгнөө /Analysis date/	Хэвлэсэн өгнөө /Printed date/	Техникийн шаардлага /Technical requirements/ MNS 4943:2015
1.5л / 1.5L /	2025.02.25	2025.02.25-03.18	2025.03.18	

№	Үзүүлэлт /Parameter/	Шинжилгээний аргын стандарт /Test method/	Шинжилгээний аргын хэмжээ /Technical specification/	Үр дүн /Test result/
1	pH-Усны орчин /Hydrogen ions, mg/L/	MNS ISO 10553-2001	6.9-9.0	7.54
2	Аммоний (NH ₄ ⁺) мг/л /Ammonia, mg/L/	MNS ISO 4428:1997	-	67.22
3	Хлорид (Cl ⁻) мг/л /Chloride, Cl ⁻ , mg/L/	MNS ISO 5297: 2007	-	202.09
4	Сульфат (SO ₄ ²⁻) мг/л /Sulfate, mg/L/	MNS ISO 6271: 2011	-	245.89
5	Уусгаар бодис, мг/л /TSS, mg/L/	MNS ISO 11923:2001	<30.0	8.60
6	Химийн хэрэгсэл хувиарлан (COD) мг/л /COD, mg/L/	ХТЛ-CA3-4/02	<50.0	243.40
7	Бiolогийн хэрэгсэл хувиарлан (BOD) мг/л /BOD, mg/L/	ХТЛ-CA3-4/01	<30.0	93.61
8	Нитрат (NO ₃ ⁻) мг/л /Nitrate, mg/L/	MNS ISO 4431:2005	-	0.32
9	Нитрат (NO ₂ ⁻) мг/л /Nitrite, mg/L/	MNS ISO 7680-3:2001	-	0.7
10	Газрын бүтэйн агаар төрөл 1 м-г	MNS 5668:2005	Илэрхий	Илэрхий

Шинжилгээ гүйцэтгэсэн /Test performed by/

Хянасан /Approved/

Шинжилгээ гүйцэтгэсэн /Test performed by/

Хянасан /Approved/

Лабораторийн эрхлэгч /Head of laboratory/

Хуудас/11

Мөн Усны тухай хуулийн 25.2, “Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулагч бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам”, “Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тооцоолох аргачлал”, “Ус бохирдуулсны төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам” -ыг тус тус үндэслэн 2025 онд ус бохирдуулсны төлбөрт гэрээний дагуу нийт 11,951,442.32 төгрөгийг татварын албанд төлж, ус бохирдуулсны төлбөрийн тайланг усны шинжилгээний хариуны хамт улирал тутамд сав газрын захиргаанд хүргүүлэн ажилласан.

2.2.4. Шинээр нүхэн жорлон байгуулахгүй байх. Ашиглагдаж буй нүхэн жорлонгуудын HDPE геомембран доторлогоонд тогтмол хяналт тавих

“Хан Алтай ресурс” ХХК-ийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний “Гадаргын ба газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ”-ний хүрээнд:

- Шинээр нүхэн жорлон байгуулахгүй байх
- Ашиглагдаж буй нүхэн жорлонгуудыг стандартжуулах

ажлын хүрээнд төслийн талбайд ашиглагдаж буй нүхэн жорлонгуудыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй, гүний усанд бохирдол үүсгэхгүй, эрүүл ахуйн шаардлагад хангасан MNS 5924:2015 стандартын дагуу тохирлын гэрчилгээтэй био жорлонгоор шинэчлэх ажлыг эхлүүлсэн.

Энэхүү ажлын хүрээнд ажлын даалгавар боловсруулж, “Их Хаан Бугуйвч” ХХК-ээс HDPE үл нэвчүүлэх худаг бүхий, тохирлын гэрчилгээтэй био жорлонг худалдан авч дараах 3 цэгт суурилуулсан:

№ Байршил	Солбилцол
1 Цахилгааны хэлтэс	46° 4' 0.89" N, 96° 52' 49.39" E
2 Нуруулдан уусгах байгууламж	46° 3' 47.37" N, 96° 52' 59.88" E
3 Мецо бутлуурын талбай	46° 6' 15" N, 96° 56' 23" E

Зураг 29. Стандартын шаардлага хангасан нүхэн жорлон, нүхэн жорлон



Зураг 30. Стандартын шаардлага хангасан нүхэн жорлон суурилуулах явц



2.2.5. Нуруулдан уусгалтын талбай болон аваарын усан сан, үерийн усан сангийн битүүмжлэлийг тогтмол хянах, гадар HDPE геомембран бүрхэвчийн эвдрэл гэмтлээс сэргийлэх, хяналт мониторинг хийх,

Усны шүүрэлтийн хяналт:

Нуруулдан уусгах байгууламжийн хяналтын 3 цооног, аваарын усан сан, үерийн усан сангийн хяналтын 1 цооногт байгууламжуудаас усны шүүрэл үүсэж байгаа эсэхийг 7 хоногт нэг удаагийн давтамжтайгаар *In-Situ Water Level Meter (100 м)* багажаар хэмжиж, тогтмол хяналт хийдэг.

Тайлант хугацаанд хийсэн хяналтын үр дүнгээр цооногуудад байгууламжаас үүдэлтэй усны шүүрэл ажиглагдаагүй байна.

Зураг 31. Нуруулдан уусгах байгууламжийн тизометрийн цооногийн хяналт



Мөн шинээр ашиглалтад орж буй нуруулдан уусгах талбайн суурийн доторлогооны системд дотоод техникийн комисс үзлэг хийж улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Нуруулдан уусгах талбайн нь нягтруулж бэлдсэн газрын гадарга, шавар үе болон геомембран, хайрга дайрган үе, хүдэр гэсэн үе давхаргуудаас бүрдэнэ.

Зураг 32. Нуруулдан уусгах байгууламжийн HDPE геомембран бүрхэвчийн хяналт



2.2.6. Дэлхийн усны өдрийн арга хэмжээний хүрээнд ус хэмнэх бүтээлч ажлыг уурхайн талбайд хийх,

“Хан Алтай ресурс” ХХК-ийн “Өргөө” кемпийн ажилчдын орон сууцанд ус хэмнэх технологийг туршилтаар нэвтрүүлж, хэрэглээний бууралтыг тодорхойлох, уурхайн дотоод ус ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилготой.

Туршилтын аргачлал:

Туршилтын ажлыг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлсэн бөгөөд “Өргөө” кемпийн ажилчдын орон сууцны угаалгын цоргуудад ус хэмнэгч хошуу суурилуулж, суурилуулалтаас өмнөх болон дараах усны хэрэглээг халуун, хүйтэн усны тоолуурын заалтаар бүртгэн харьцуулсан.

- Туршилт 1: Нийт 36 угаалгын цорго (29 өрөө + 6 нийтийн угаалгын өрөө)
- Туршилт 2: Нийт 128 өрөөний угаалгын цорго

- Хэмжилт: Суурилуулалтаас өмнөх болон дараах 7 хоногийн дундаж хэрэглээ
- Багаж, арга: Усны тоолуурын өдөр тутмын заалтад тулгуурлан тооцоолсон

Туршилтын үр дүн

Туршилтын үе шат	Хамрагдсан өрөө / цорго	Суурилуулалтаас өмнөх усны хэрэглээ (м³/хоног)	Суурилуулсны дараах усны хэрэглээ (м³/хоног)	Хэмнэлт (м³/хоног)	Хэмнэлт (%)
Туршилт 1	36 цорго (29 өрөө + 6 нийтийн өрөө)	61.4	44.6	16.8	27.3%
Туршилт 2	128 өрөө	26.6	11.2	15.4	57.9%


Дүгнэлт

- Ус хэмнэгч хошууг ажилчдын орон сууцанд туршилтаар суурилуулснаар усны хэрэглээ дунджаар 27–58% хүртэл буурч, бодит ус хэмнэлтийн үр дүнтэй болох нь тогтоогдсон.
- Ус хэмнэх төхөөрөмжийг уурхайн бусад кемп, оффисын хэрэглээний усанд өргөтгөн нэвтрүүлэх нь усны нөөцийг хамгаалах, төлбөрийн зардлыг бууруулах, MNS 4943:2015 стандартын хүрээнд ус хэмнэлтийн бодлого хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэв.

Зураг 33. Суурилуулсан ус хэмнэгч цорго



График 5. Ус хэмнэгч цорго суурилуулахаас өмнөх болон дараах үеийн АОС-ны усны хэрэглээ



■ Ус хэмнэгч цорго суурилуулсны дараах усны хэрэглээний буурсан хувь



2.2.7. Цэвэр ус цэвэршүүлэх байгууламжийг ашиглаж ажилчдыг унд ахуйн усны стандартын шаардлага хангасан усаар хангах

“Хан Алтай ресурс” ХХК нь ажилчдыг унд, ахуйн зориулалтын стандартын шаардлага хангасан усаар хангах зорилгоор Цэвэр ус цэвэршүүлэх байгууламжийг ашиглалтад оруулсан.

Кемпийн усан хангамжийн ГХ-01, ГХ-02 гүний худгуудад эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, хашаа хамгаалалт хийсэн бөгөөд “Тоолууржуулах журам”-ын дагуу усны тоолуур суурилуулан ашиглалтыг эхлүүлсэн.

Цэвэр ус цэвэршүүлэх байгууламж болон гүний худгуудын усыг MNS 0900:2018 “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдал” стандартаар шинжилж, дараах үр дүн гарсан байна.

Усны эх үүсвэр	Шинжилгээний үнэлгээ	Тайлбар
Гүний худаг №1	Цэнгэгдүү, хатуу ус	Байгалийн найрлага өндөр, эрдэсжилт ихтэй
Цэвэршүүлсэн ус	Нэн цэнгэг, маш зөөлөн ус	Унд ахуйн хэрэглээнд бүрэн тохиромжтой

Шинжилгээний үр дүнгээс үзэхэд цэвэршүүлсэн ус нь ундаанд хэрэглэхэд тохиромжтой, чанарын шаардлага хангасан болох нь тогтоогдсон бөгөөд уурхай дахь ажилчдын унд, ахуйн хэрэглээнд тогтвортой нийлүүлж байна.

Зураг 34. Цэвэршүүлсэн ус, Гүний худаг 1, Гүний худаг 2

[illegible]

2.2.8. Хүдэр боловсруулах үйлдвэрт ашиглагдаж байгаа усыг 70% хүртэл эргүүлэн ашиглах.

“Хан Алтай” ордын исэлдсэн хүдрийг уусган баяжуулах үйлдвэрийн усны балансын тооцоогоор хоногт дунджаар 1,340.4 м³ цэвэр ус хэрэглэж байна. Үйлдвэрийн технологийн процесст ашиглагдсан усыг цуглуулах, цэвэршүүлэх, дахин ашиглах усны эргэлтийн систем бүрэн ажиллагаатай бөгөөд жилд дунджаар 86.4–87.86% хүртэлх хэмжээгээр технологийн усыг эргүүлэн ашиглаж байна.

Тайлант онд ашигт малтмал олборлох зориулалтаар нийт 361,919.00 м³ ус ашигласнаас 81% нь эргүүлэн ашиглагдсан бөгөөд энэ нь үйлдвэрийн усны хэрэглээг оновчтой болгож, шинэ цэвэр усны хэрэглээг бууруулан байгалийн усны нөөцийг хамгаалах ач холбогдолтой байна.

Ийнхүү үйлдвэрийн технологийн процессуудад усны эргэлтийн системийг үр ашигтай хэрэгжүүлснээр усны хэрэглээний зардлыг бууруулахын зэрэгцээ усны нөөцийн тогтвортой менежмент, байгаль орчны хамгаалалд чухал хувь нэмэр оруулж байна.

Хүснэгт 16. Хүдэр боловсруулах үйлдвэрийн ус ашиглалт

Зориулалт	Jan	Feb	Mar	1-р улирал	Apr	May	Jun	2-р улирал	Jul	Aug	Sep	3-р улирал
Зам талбайн тоосжилт	541	2,871	4,574	7,986	6,833	5,074	8,402	20,309	8,168	8,473	8,705	25,346
Эрэл хайгуул, өрөмдлөг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Ногоон байгууламж	-	-	37	37	566	759	811	2,136	673	688	474	1,835
Барилга байгууламж	-	-	-	-	-	-	-	-	-	35	-	35
Дулаан хангамж	457	184	186	827	1,613	1,131	1,032	3,776	519	726	-	1,245
Ашигт малтмал олборлох	18,703	19,523	31,268	69,494	62,691	50,261	50,867	163,819	52,840	39,903	35,863	128,606
Унд ахуйн ус	2,414	2,375	1,745	6,534	1,925	2,020	1,952	5,897	1,812	1,379	1,421	4,612

2.2.9. Усыг ариг гамтай ашиглах сургалт ажилчдад орох

“Хан Алтай Ресурс” ХХК нь усны нөөцийг хамгаалах, хэрэглээг бууруулах, ажилчдын дунд ус хэмнэх дадлыг төлөвшүүлэх зорилгоор усыг ариг гамтай ашиглах чиглэлээр сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа зохион байгууллаа.

Тус ажлын хүрээнд “Өргөө” кемпийн ажилчдын орон сууцанд ус хэмнэх технологи (ус хэмнэгч хошуу)-г туршилтаар нэвтрүүлж, усны хэрэглээг дунджаар 27–58% хүртэл бууруулсан бодит үр дүнтэй арга хэмжээг таниулав.

Ус хэмнэгч хошууны ашиглалтын зааварчилгаа, хэрэглээний зөв дадал-ыг уурхайд ажиллаж буй үндсэн болон гэрээт компанийн нийт ажилчдад танилцуулж, сургалт зохион байгуулсан.

Мөн 2025 оны 3 дугаар сарын 22-ны өдөр – Дэлхийн усны өдрөөр бүх газар, хэлтэс, нэгжийн ажлын талбайд очиж:

- Усны нөөцийн хомсдол, уурхайн усны хэрэглээний ач холбогдол,
- Ус хэмнэх технологи болон дахин ашиглалтын ач холбогдлын талаар сургалт болон постер мэдээлэл хүргүүлж, усыг хэмнэх хандлагыг төлөвшүүлэх үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан.

Тус сургалтыг уурхайн ээжлийн нийт ажилчдад зохион байгуулж нийт 216 ажилтанд 107 хүн цаг сургалтыг орсон.

Зураг 35. Ус хэмнэхтэй холбоотой сургалтын мэдээлэл, постер



2.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2.3.1. Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдлыг зориулалтын талбайд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх, дахин боловсруулах үйлдвэртэй гэрээ байгуулан нийлүүлэх.

Аюултай хог хаягдлын хяналтын арга хэмжээ

Тайлангийн хугацаа: 2025 оны 1–3 улирал (2025/01/01 – 2025/10/01)

1. Ерөнхий мэдээлэл

Аюултай хог хаягдал түр хадгалах талбайн зохион байгуулалт: Мөслийн талбайд “Ашигласан тос тосолгооны материал түр хадгалах талбайг” хөрсөн бүрхэвчид сөрөг нөлөө үлүүлэх нөхцөлөөр дараах байдлаар шийдвэрлэсэн. Үүнд:

- Улаан шавар 20 см дэвсэж,
- Геомембранаар бүрэн хучиж,
- Дээр нь 10 см хайрга дэвсэж нягтаршуулсан,
- Хамгаалах хөмсөг, таних тэмдэг, тэмдэглэгээ суурилуулсан.

Тус талбайд түр хадгалагдаж буй аюултай хог хаягдлыг тогтмол бүртгэлжүүлж, эрх бүхий байгууллагаар устгуулж байна.

Зураг 36. Техникийн засвар үйлчилгээнээс гарсан аюултай хог хаягдал түр хадгалах талбай



2. Аюултай хог хаягдал устгах байгууллагын мэдээлэл

Үзүүлэлт	Мэдээлэл
Бүртгэлийн дугаар	901153065
Аж ахуйн нэгжийн нэр	“Түмэн Эгшиг” ХХК
Байгууламжийн нэр	Аюултай хог хаягдал хүлээн авах цэг
Байршил	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 16-р хороо, Ойчдын 1-128 тоот

3. Хог хаягдал үүсгэгч байгууллагын мэдээлэл

Үзүүлэлт	Мэдээлэл
Бүртгэлийн дугаар	000179664
Аж ахуйн нэгжийн нэр	“Хан Алтай ресурс” ХХК

4. Устгасан аюултай хог хаягдлын бүртгэл

№	Код	Хог хаягдлын төрөл	Хэмжээ	Нэгж	Устгасан арга
1	060101*	Азот оролцсон химийн процессоос үүсэх хортой бодис	317	кг	Шилжүүлсэн
2	110301*	Цианид агуулсан хаягдал	3,547	кг	Шилжүүлсэн
3	060405*	Бусад хүнд металл агуулсан хаягдал	3,854	кг	Шилжүүлсэн
4	060405*	Бусад хүнд металл агуулсан хаягдал	4,915	кг	Шилжүүлсэн
5	060405*	Бусад хүнд металл агуулсан хаягдал	850	кг	Шилжүүлсэн
6	060101*	Азот оролцсон хортой бодис	300	кг	Шилжүүлсэн
7	060101*	Азот оролцсон хортой бодис	8	кг	Шилжүүлсэн
8	130205*	Хөдөлгүүр, хурдны хайрцгийн болон тосолгооны бусад тос	11,000	кг	Шилжүүлсэн
9	060405*	Бусад хүнд металл агуулсан хаягдал	1,500	кг	Шилжүүлсэн
10	160104*	Тосны шүүр	2,400	кг	Шилжүүлсэн
11	160701*	Тос агуулсан хаягдал	200	кг	Шилжүүлсэн
12	160701*	Тос агуулсан хаягдал	7,000	кг	Шилжүүлсэн
13	160701*	Тос агуулсан хаягдал	3,000	кг	Шилжүүлсэн
14	110301*	Цианид агуулсан хаягдал	17,500	кг	Шилжүүлсэн
15	060101*	Азот оролцсон хортой бодис	210	кг	Шилжүүлсэн
16	130205*	Хөдөлгүүр, хурдны хайрцгийн болон тосолгооны бусад тос	188	кг	Шилжүүлсэн

5. Хог устгалын хяналт, тайлагнал

- 2025 онд нийт 56,8 тонн, 17 төрлийн аюултай хог хаягдлыг шилжүүлэн, устгуулж нийт **295,737,486 төгрөгийн төлбөрийг төлсөн** бөгөөд бүртгэлийг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 421 дугаар тушаалын 8 дугаар хавсралт загвараар бүртгэн хөтөлж, БОМТ-ын тайлангийн хавсралтаар БОУӨЯ, Говь-Алтай аймгийн Байгаль орчны газар, Есөнбулаг сумын ЗДТГ-т тус тус хүргүүлсэн.
- Устгал хийгдсэн тухай бүр гэрээт байгууллагын акт, гэрчилгээ авч хадгалж байна.
- Тайланг жил бүр Байгаль орчны газарт хүргүүлж, хяналтын байгууллагад бүртгүүлж байна.

2.3.2. Тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулах, химийн бодисыг хөрсөнд алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх

“Хан Алтай ресурс” ХХК нь уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж буй химийн бодисуудын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт болон устгалын бүхий л шатанд холбогдох хууль, стандартын шаардлагыг чанд мөрдөн ажиллаж байна.

1. Химийн бодис хадгалах байгууламж

Компанийн химийн бодис хадгалах агуулах нь 2022 оны 8 дугаар сард ашиглалтад орсон бөгөөд Говь-Алтай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Ш.Мөнхцэцэг, Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны улсын байцаагч М.Сүнжидмаа нарын хамтарсан хяналт шалгалтад хамрагдаж, **MNS 6458:2014, MNS 4990:2015** стандартуудын шаардлагыг бүрэн хангаж буй талаар дүгнэлт гаргасан.

Агуулахын нийт талбай **528 м²**, 440 тонн багтаамжтай ба дараах хамгаалалтын байгууламжуудаар тоноглогдсон:

- Улаан шавар, геомембран, хайрга үе бүхий дэвсгэр суурьтай;
- Асгаралт, алдагдал үүсэхээс хамгаалсан хөмсөг, нүх, сувагтай;

- Агааржуулалт, гэрэлтүүлэг, температур, чийгийн горимыг стандартад нийцүүлэн тохируулсан;
- Аюултай химийн бодисын нэр, анхааруулах тэмдэг, MSDS мэдээллийг байршуулсан;
- Химийн бодис асгарах, алдагдах, гал түймэр гарах зэрэг онцгой нөхцөлд шуурхай хариу арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулан мөрдөж байна.

Агуулахын дотор температур дунджаар 18–20°C, харьцангуй чийгшил 30–40%, гэрэлтүүлэг 100–150 люкс, дуу чимээний түвшин 40–45 дБ байгаа нь стандартын шаардлагыг бүрэн хангаж байна.

2. Тээвэрлэлтийн зохион байгуулалт

Химийн бодисын тээвэрлэлтийг тусгай зөвшөөрөл бүхий “Гигатранс” ХХК-аар тусгай маршрутын дагуу гүйцэтгэж байна.

Тээвэрлэлтийн явцад дараах аюулгүй ажиллагааг ханган ажилладаг:

- Химийн бодис бүрийн аюулгүй байдлын мэдээллийн хуудас (MSDS)-ыг тээврийн бичиг баримтад хавсаргадаг;
- Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг урьдчилан шалгаж, шаардлагатай хамгаалах хэрэгсэл, шошго, анхааруулах тэмдэг байршуулдаг;
- Тээврийн ажилтнуудад химийн бодистой харьцах аюулгүй ажиллагааны сургалт, зааварчилгаа өгдөг;
- Тээвэрлэлтийн үеийн осол, асгаралт, алдагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлдэг.

3. Хяналт, тайлагнал

Химийн бодис хадгалалт, тээвэрлэлтийн явцад байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор:

- Хадгалалтын байр, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж,
- Асгаралт, алдагдал илэрсэн тохиолдолд нэн яаралтай арга хэмжээ авах журмыг мөрдөж,
- Химийн бодисын бүртгэл, орлого, зарлагын тайланг жил тутам гаргаж, холбогдох төрийн байгууллагад тайлагнаж байна.

Зураг 37. Урвалжийн агуулах харагдац, тоноглол





2.3.3. Химийн бодис хөрсөнд алдагдаж бохирдолд үүссэн тохиолдолд саармагжуулах болон цэвэрлэх арга хэмжээг авах, цэвэрлэгээний дараах хяналт мониторингийг хийх, Асгаралтын үед шуурхай хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх асгаралтын иж бүрдлийг нэмэгдүүлэх, бэлэн байлгах.

“Хан Алтай Ресурс” ХХК нь уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж буй химийн бодисыг холбогдох хууль, стандартын дагуу хадгалах, тээвэрлэх, ашиглах, хянах журамтайгаар ажилладаг. Химийн бодис алдагдаж хөрсөнд бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэх, тохиолдлын үед шуурхай арга хэмжээ авах зорилгоор “Асгаралтын үед авах хариу арга хэмжээний журам”-аар зохицуулж ажилладаг.

1. Химийн бодис хадгалалтын нөхцөл

- Химийн бодис хадгалах зориулалтын агуулах нь улаан шавар 20 см дэвсэж, HDPE геомембран хучилттай, 10 см хайрган үе болон хамгаалах хөмсөгтэй.
- Агуулах нь механик болон агааржуулалтын системтэй, битүүмжлэл сайтай, асгаралт гадагш алдагдах нүх сүвгүйгээр баригдсан.
- Агуулахын орчны гэрэлтүүлэг, температур, чийгшил, дуу шуугианы түвшин нь MNS 4990:2015 стандартын шаардлагыг хангаж байна.
- Химийн бодисын агуулах, ашиглалт, хяналт шалгалтын талаар Говь-Алтай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлтээр стандартын шаардлагыг бүрэн хангаж ажиллаж буй нь баталгаажсан.

2. Химийн бодис асгарсан тохиолдолд авах арга хэмжээ

- Асгаралт, алдагдал илэрсэн тохиолдолд тухайн бүсийг даруй тусгаарлаж, ажилтнуудыг нүүлгэн шилжүүлнэ.
- Асгарсан бодисын төрөл, хэмжээг тодорхойлж, саармагжуулах бодис (шохой, сода, идэвхжүүлсэн нүүрс гэх мэт) ашиглан анхан шатны саармагжуулалт хийнэ.
- Саармагжуулалтын дараа бохирдсон хөрсийг тусгай зориулалтын саванд хийж Гигатранс ХХК-ийн тусгай маршрутаар “Түмэн Эгшиг” ХХК-д хүргүүлэн устгуулна.

3. Сургалт, бэлэн байдлын ажиллагаа

- “Асгаралтын үед авах арга хэмжээний журам”-ын дагуу 2025 оны 6 дугаар сард уурхайн ажилтнуудад химийн бодис асгаралтын үед авах хариу арга хэмжээ, анхны тусламж, мэдээлэл өгөх дарааллын талаар сургалтыг мэргэжлийн байгууллага болох Аршхур ХХК-р химийн бодистой харьцан ажилладаг 31 ажилтанд төслийн талбай дээр сургалт зохион байгуулсан.

4. Дүгнэлт

- Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт нь холбогдох хууль, стандартуудын дагуу хийгдэж байна.
- Ослын үед авах арга хэмжээний бэлэн байдал хангагдсан, сургалт, дадлагаар баталгаажсан.
- Цаашид химийн бодисын хадгалалтын орчинд сарын хяналт, жил бүрийн эрсдэлийн үнэлгээ, ослын бэлэн байдлын сургалт тогтмол зохион байгуулж ажиллана.

Зураг 38. Асгаралтын иж бүрдлийг УАХ оффис болон ТЗҮХ-ийн дуудлагын машинд суурилуулсан



Зураг 39. Асгаралтын үед хариу арга хэмжээ авах давтан зааварчилгаа




2.3.4. Шаардлагагүй олон салаа зам үүсгэхгүй байх, маршрутаас өөр замаар юм уу эсвэл шинээр зам үүсгэн зорчсон тээврийн хэрэгсэлд хариуцлага тооцох.

Төслийн талбайд ашиглагдахгүй болсон 2.2 км урттай авто замыг хаасан. Зам хаах арга хэмжээ нь уурхайн дотоод хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөрсний эвдрэл, тоосжилт бууруулах ач холбогдолтой.

Хөрсний нөхөн сэргээлт: Хаасан замын дагуух хөрсийг сийрүүлж, техникийн нөхөн сэргээлт хийсэн. Энэхүү үйл ажиллагаа нь хөрсний тогтвортой байдлыг хангах, байгаль өөрөө нөхөн сэргэх боломж бүрдсэн.

Зураг 40. Төслийн талбайн зам сүлжээ, хаасан зам



2.4. Газрын гадарга, хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн дэлгэрэнгүй

2.4.1. Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх ажлыг эхлүүлэхийн өмнө “Газар хөндөх зөвшөөрөл”-ийг өгөх


Тайлант 2025 онд аливаа газар хөндөх ажлыг эхлүүлэхээс өмнө “Газар хөндөх зөвшөөрөл” олгож ажилласан. Нийт 7 газар, 80,927 м² талбайд газар хөндөх зөвшөөрөл олгож, 16,185 м³ шимт хөрс хуулсан байна.

Талбай	Талбайн хэмжээ (м ²)	Үйл ажиллагаа
Боловсруулах үйлдвэр нүүрс буулгах талбай	14,510	Нүүрс буулгах
Хансуун бутлуур талбай тэлэх	3,868	Талбай өргөтгөл
Дром талбай сунгах	19,529	Талбай сунгалт
Мужаан цех барих	16,000	Барилга байгууламж
Спорт заал барих	5,800	Барилга байгууламж
Ажилчдын орон сууц барих	6,900	Барилга байгууламж
Хөрсний овоолго тэлэх	14,320	Хөрсний хадгалалт

Газар хөндөх зөвшөөрөл олгохын өмнө маягтын дагуу дараах асуудлыг тодорхойлсон:

- Ховор ургамлын бүлгэмдэл, шилжүүлэн суулгах шаардлага
- Мэрэгч амьтдын гол төлөөлөл, нөлөөлөх хүчин зүйл
- Түүх соёлын өвтэй холбогдох асуудал
- Шимт хөрсийг хэр зузаантай хуулах тооцоолол
- Нэмэлт шаардлага, хяналт, зохицуулалт

Зураг 41. Газар хөндөх зөвшөөрлийн маягтууд /дромын талбай сунгах/



2.4.2. Машин техникийн засвар үйлчилгээ, элэгдэл, эвдрэлээс гарсан шингэн хаягдал, тос масло асгарсан тохиолдолд хүнд металлын бохирдол нэмэгдэхээс урьдчилан сэргийлж засварын талбайг цементлэх, Өргөө кемп, ТЗҮХ, БҮХ-ийн халаах зуухны нүүрс буулгах талбайг засварлаж цементлэх

Хан Алтай төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт дүгнэсэн ажлын хэсгийн өгсөн зөвлөмжийн дагуу тайлант онд нийт 2,708.1 м² талбайд, 742 м³ бетонжуулах ажил хийгдсэн.

- Тайлант хугацаанд доорх талбайд бетонжуулах ажил хийгдсэн, ингэснээр:

- Техник засвар үйлчилгээний талбайд шингэн хаягдал, тос, масло асгарах тохиолдолд хөрс бохирдохгүй байх нөхцөл бүрдсэн.
- Нүүрс, үнсний талбайн хүнд металлын хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлсэн.
- Аюултай хог хаягдлын хяналт сайжрах нөхцөл бүрдэж байна.
- Энэхүү бетонжуулах ажил нь 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зөвлөмжийг хэрэгжүүлсэн ажил болсон.

Хүснэгт 17. Бетонжуулалтын ажил

№	Байршил	Талбайн хэмжээ	Бетоны хэмжээ	Зураг
1	Техник засвар үйлчилгээний засварын талбай	624м ²	168м ³	
2	Өргөө зуухны нүүрсний талбай	310м ²	83м ³	
3	Боловсруулах үйлдвэрийн зуухны нүүрсний талбай	1269м ²	300м ³	
4	Боловсруулах үйлдвэрийн зуухны үнсний талбай	291м ²	67м ³	
5	Техник засвар үйлчилгээний зуухны нүүрсний талбай	57,6м ²	17м ³	

6	Техник засвар үйлчилгээний зуухны үнсний талбай	23м2	7м3	
7	Боловсруулах үйлдвэр Аюултай хог хаягдлын агуулах	133.5м2	100м3	

2.4.3. 2025 онд газрын хэмжээ өөрчлөгдсөн болсон шинээр олгосон газруудад Газрын төлөв байдал чанарын хянах баталгаа хийлгэх,

Төслийн хүрээнд 2025 онд газар эзэмших эрх дуусгавар болгох, нэгж талбаруудыг нэгтгэх, талбайн хэмжээг өөрчлөх болон шинээр газар эзэмших ажлууд зохион байгуулагдсан.

Хийгдсэн ажлууд:

- 2025 онд газар эзэмших эрх, талбайн мэдээллийг шинэчлэх хүрээнд Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Засаг даргад шаардлагатай хүсэлтүүдийг хүргүүлж 2024 онд эзэмшиж байсан нийт 50 нэгж талбарыг нэгтгэн 14 нэгж талбар болгон нэгтгэж, холбогдох гэрээг байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ авсан.
- Газар эзэмшлийн бүтэц, хил заагийн өөрчлөлтөд тулгуурлан 9 нэгж талбарт өөрчлөлт орсон бөгөөд эдгээр талбайд “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа” хийх ажлын даалгавар боловсруулсан.

Одоогийн байдал:

- Хянан баталгааг гүйцэтгэх мэргэжлийн байгууллагын сонгон шалгаруулалтын ажил явагдаж байна.
- Уг шалгаруулалтын үр дүнд сонгогдсон байгууллагаар газар ашиглалтын төлөв байдал, хөрсний чанарын суурь судалгаа, үнэлгээ, баталгаажуулалтыг гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Зорилго:

- Газрын ашиглалтын нэгдсэн мэдээллийн санг шинэчлэх,
- Эзэмшлийн хил зааг, зориулалтыг хууль эрх зүйн хүрээнд баталгаажуулах,
- Байгаль орчны нөлөөллийг бууруулах газар ашиглалтын оновчлол хийх.

Хүснэгт 18. Газрын кадастрын систем | Dashboard

№	Зориулалт	Иргэн/Хуулийн этгээд	Талбайн хэмжээ	Нэгж талбар
1	Холбоо, мэдээлэл дамжуулах, хүлээн авах станц	Хан-Алтай ресурс ХХК	15189	8208006705
2	Ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн талбай	Хан-Алтай ресурс ХХК	282959	8208006706
3	Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж	Хан-Алтай ресурс ХХК	299857	8208006724
4	Цахилгаан, эрчим хүчний барилга байгууламж	Хан-Алтай ресурс ХХК	300336	8208006714
5	Уурхайн газар	Хан-Алтай ресурс ХХК	1957822	8208007290
6	Уурхайн газар	Хан-Алтай ресурс ХХК	3187384	8208007293
7	Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж	Хан-Алтай ресурс ХХК	26108	8208007289
8	Уурхайн газар	Хан-Алтай ресурс ХХК	1079106	8208007287
9	Ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн талбай	Хан-Алтай ресурс ХХК	15009	8208007286
10	Уурхайн газар	Хан-Алтай ресурс ХХК	7508765	8208007294
11	Уурхайн газар	Хан-Алтай ресурс ХХК	4135953	8208007292
12	Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж	Хан-Алтай ресурс ХХК	14986	8208007288
13	Хайгуулын кемп	Хан-Алтай ресурс ХХК	205252	8208006725
14	Уурхайн газар	Хан-Алтай ресурс ХХК	136045	8208007291

Зураг 42. Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа ажлын даалгавар

[illegible]

2.5. Ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2.5.1. Өргөө кемпийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг хэрэгжүүлэх, мөн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Хан-Алтай төслийн талбайд 2025 онд бүх нийтээр мод тарих ажлыг Хаврын болон Намрын улиралд амжилттай зохион байгууллаа.

1. Хаврын тарилт

Өргөө кемпийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд кемпийн хашаа дагуу хамгаалалтын зурвас байгуулж, постын зам дагуу болон мод үржүүлгийн талбайд нөхөн тарилт хийсэн.

Мод тарьсан байршлууд:

- Өргөө кемп хашаа дагасан хамгаалалтын зурвас (улиас, хайлаас)
- Пост-1 зам дагуу мод нөхөн тарилт (улиас)
- Мод үржүүлгийн газрын хамгаалалтын зурвас, хүлэмжийн нөхөн тарилт (агч, гүйлс, улиас)

№	Модны нэр	Талбай (урт)	Тарих зай	Тарилтын тоо (ш)
1	Улиас	410 м	2 м	750
2	Хайлаас	410 м	1 м	820
3	Шар хуайс	200 м	1 м	300
4	Гүйлс	100 м	1 м	100
5	Агч	100 м	1 м	100
Нийт				2,070 мод

Зураг 43. Хаврын бүх нийтээр мод тарилт



2. Намрын тарилт

2025 оны намрын мод тарих ажлын хүрээнд Өргөө кемпийн СОС оффисын дөрвөн талд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор мод тарьсан.

Мод тарьсан байршил:

- Өргөө кемпийн СОС оффис (агч, хайлаас)

№	Модны нэр	Талбай (урт)	Тарих зай	Тарилтын тоо (ш)
1	Хайлаас	120 м	2 м	600
2	Агч	350 м	2 м	50
Нийт				650 мод

Зураг 44. Намрын бүх нийтээр мод тарилт



- 2025 онд нийт 2,720 ширхэг мод тарьж, Өргөө кемпийн орчны ногоон байгууламжийг өргөтгөн, хамгаалалтын зурвасыг шинэчилсэн.
- Тарьсан моднуудын 80 орчим хувийг нутагшсан, хуурайшилт тэсвэртэй зүйлийн мод бут (улиас, хайлаас, шар хуайс) бүрдүүлсэн.
- Тарилтын дараах арчилгаа, усалгааг хуваарийн дагуу зохион байгуулж, ургалтын хяналт хийж байна.

2.5.2. Уурхай орчмын ургамлын үр түүх, үрийн фонд үүсгэх

Төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу уурхайн нөхөн сэргээлтийн ажлын чанарыг сайжруулах, нутгийн унаган ургамлын төрөл зүйлээр нөхөн сэргээх зорилгоор ургамлын үр түүх, үрслүүлэг, үрийн фонд үүсгэх ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна.

1. Үр түүх, бэлтгэлийн ажил

№	Ургамлын төрөл	Латин нэр	Үр түүсэн байршил	Үрийн хэмжээ	Үрийн боловсруулалт
1	Шинэс	<i>Larix sibirica</i>	Зайврын Шинэсэн ой	5 кг	Цагаалаагүй үрийг хатааж, дэвүүрээс салгах бэлтгэл хийгдэж байна
2	Заг	<i>Haloxylon ammodendron</i>	Бигэрийн Заган бүлгэмдэл	2 кг	Үрийг хатааж, дэвүүрээс салгах ажлыг үргэлжлүүлж байна

Нийт үрийн хэмжээ: 7 кг

Үрийн төрөл: 2 (уур амьсгалд зохицсон модлог ургамлын зүйл)

2. Үрсэлгээ ба суулгац бэлтгэлийн ажил

№	Ургамлын төрөл	Үр/мөчирийн эх үүсвэр	Тарьсан орчин	Тоо хэмжээ
1	Улиас	Бигэр сум мод үржүүлгийн газар (саваа мөчир)	Хүлэмж	300 ширхэг (харандаа суулгац)
2	Харгана, Хармаг	Хан Алтай мод үржүүлгийн газар (2023 онд үрээр үрслүүлсэн)	Бойжуулах талбай	600 ширхэг

3. Ажлын үр дүн, ач холбогдол

- Төслийн талбай орчимд ургадаг уур амьсгалд дасан зохицсон унаган ургамлын үр цуглуулснаар нөхөн сэргээлтэд ашиглах биологийн суурь нөөц бүрдэв.
- Үрийн боловсруулалт, хадгалалтын ажлыг явуулснаар үрийн соёололтын чадварыг хадгалж, дараагийн улиралд үрслүүлэх боломж бүрдэв.
- Хүлэмжид болон бойжуулах талбайд суулгац ургуулах замаар нутгийн ургамлын үржүүлгийн тогтвортой системийг бүрдүүлэх ажлын эхлэл тавигдлаа.

4. Цаашдын төлөвлөгөө

- Үрийн фондын нөөцийг жил бүр шинэчилж, төрөл зүйлийг нэмэгдүүлэх,
- Хүлэмжийн үрсэлгээг өргөжүүлж, нөхөн сэргээлтэд туршилтаар ашиглах,

Зураг 45. Шинэс модны үр түүж бэлтгэв



Зураг 46. Заг модны үр түүж бэлтгэв



Зураг 47. Улиас модны мөчир бэлтгэж үрслүүлэв



Зураг 48. Харгана, Хармаг бойжуулах талбайд гаргав




2.5.3. Уурхайн талбайн ургамлын мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх

Уурхайн талбайн ургамлын ургалтын эхний үеийг үнэлэх зорилгоор 2025 оны 6 дугаар сард мэргэжлийн байгууллага Эко Эстимэйт ХХК ургамлын мониторинг судалгааг гүйцэтгэсэн. /Тайлангийн 9-р бүлгээс дэлгэрэнгүй үзнэ үү/

- Судалгааны хүрээнд:
 - Ургамлын аймаг, төрөл зүйл, бүрхцийн тархалт
 - Ургамлын ургалтын эхний үеийн трансектийн дагуу судалгааны 10 цэгт ургамлын бичиглэл хийгдсэн.
- Энэхүү судалгаа нь нөхөн сэргээлт, мод үржүүлэг, ургамлын нөхөн сэргээх ажлын үр дүнг үнэлэх, цаашид төсөлд тохирсон ургамлын менежментийг төлөвлөх суурь мэдээлэл болж байна.

Зураг 49. Ургамлын судалгааны үе



2.6. Амьтан аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2.6.1. Орон нутгийн байгууллагуудтай хамтран зэрлэг ан амьтанд өвөл, хаврын үед биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх

“Биотехникийн арга хэмжээ” гэж зэрлэг амьтдын амьдрах болон идэш тэжээлийн нөхцөлийг сайжруулах зорилгоор хэрэгжүүлдэг үйл ажиллагааг хэлнэ.

Эдгээрт цас зуд, ган гачиг, байгалийн онц аюултай үзэгдэл зэрэг шалтгаанаар амьтад өвс тэжээл, усны хомсдолд орсон үед өвс, хужир тавьж өгөх, усны эх үүсвэрийг цэвэрлэх, мөс хагалж ус гаргах зэрэг арга хэмжээ багтдаг.

Цэг тогтоосон тухай

Байгаль орчны баг нь зэрлэг амьтдын ажиглалт, хяналт мониторингийн ажлыг 7 хоног бүрийн бямба гаригт тогтмол хийж гүйцэтгэдэг. Энэ ажлын хүрээнд төслийн талбайн нөлөөллийн бүсэд нийт 4 ажиглалтын цэг тогтоож, тус цэгүүдэд ажиглагдсан амьтдын нэр төрөл, тоо хэмжээ, хүйс, байршлыг бүртгэн амьтны ажиглалтын хуудсанд тэмдэглэж хяналт мониторинг хийдэг.

Эдгээр тэмдэглэлд үндэслэн амьтдын байршлын мэдээллийг тодорхойлж, биотехникийн арга хэмжээг амьтдын идээшилт идэвхтэй явагддаг бүсүүдэд хэрэгжүүлсэн.

Гүйцэтгэсэн ажлын тухай

“Хан-Алтайн алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах төсөл”-ийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025”-ийн “Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан “Орон нутгийн байгууллагуудтай хамтран зэрлэг ан амьтанд өвөл, хаврын үед биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх” ажлын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэв.

Хэрэгжүүлсэн биотехникийн арга хэмжээний дэлгэрэнгүй

№	Амьтны төрөл	Байршил	Огноо	Хэрэгжүүлсэн ажил	Хэмжээ (пресс өвс)
1	Хар сүүлт зээр (<i>Gazella subgutturosa</i>)	Улаан шаврын урд өргөн сайр	2025он 01 сар	Өвс тавьж өгөх	20
			2025он 02 сар	Өвс тавьж өгөх	8
2	Янгир ямаа (<i>Capra sibirica</i>)	Бөөрийн амны дээд эх	2025он 01 сар	Өвс тавьж өгөх	12
			2025он 02 сар	Өвс тавьж өгөх	10
Нийт дүн:					46 пресс
3	Есөнбулаг сумын Байгаль орчны багт хүлээлгэн өгсөн		2025он 03 сар	Хүлээлгэн өгсөн	50 пресс

- Биотехникийн арга хэмжээг төлөвлөгөөний дагуу 2 удаа хэрэгжүүлсэн бөгөөд зэрлэг амьтдын идэш тэжээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн.
- Ажиглалтын цэгүүдэд зээрийн сүрэг болон янгирын бүлгүүд тогтмол ажиглагдаж, өвсний хэрэглээний ул мөр илэрсэн.
- 200 пресс өвсний худалдан авалт хийгдсэн, Есөнбулаг сумын Байгаль орчны тасагтай хамтран биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Зураг 50. Хар Сүүлтий зээр биотехникийн арга хэмжээ



Зураг 51. Янгир биотехникийн арга хэмжээ



Зураг 52. Есөнбулаг суманд зэрлэг амьтанд тавьж өгөх 50 пресс өвс хүлээлгэн өгөв



2.6.2. Төслийн талбайн зэрлэг ан амьтадын шилжилт хөдөлгөөнийг судлах зорилгоор камерын мониторинг ажиглалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийх,

Төслийн талбайн зэрлэг амьтдын тархалт, шилжилт хөдөлгөөн, амьдрах орчны ашиглалт-ыг судлах зорилгоор мэргэжлийн байгууллага болох Эко Эстимэйт ХХ-тай хамтран уурхай орчмын амьтны ажиглалтын цэг, уст цэгүүдэд амьтны хяналтын камер суурилуулан Уурхайн үйл ажиллагаанаас үүдэн амьтдын байршил, сүргийн бүрдэлд орж буй өөрчлөлт, Амьтдад зориулан бүтээн байгуулсан уст цэг, тэжээлийн ашиглалт хэр үр дүнтэй байгааг үнэлэх.

1. Судалгааны арга зүй, багаж хэрэгсэл

- **Ажиглалтын цэг тогтоох:** Байгаль орчны баг 7 хоног бүрийн бямба гаригт амьтдын төлөв, тоо, төрөл, хүйс, байрлал-ыг ажиглах.
- **Камерын мониторинг:** Амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөн, уст цэгт хандалт-ыг мэдрэгч автомат камерын тусламжтайгаар судалсан.
- **Мэдээлэл боловсруулах арга зүй:**
 1. Камерууд системтэй байрлуулж дугаарласан.
 2. Камерт хадгалагдсан зургийг тус бүрээр хавтас үүсгэн хадгална.
 3. P1E программыг ашиглан зургуудыг 1-р зургаас эцсийн зураг хүртэл дугаарлана.
 4. Он сар, өдөр, цаг минут секундний мэдээллийг MS Excel-р хөрвүүлэн, тухайн зургийн амьтантай тааруулан бүртгэх.
 5. Амьтны төрөл, нас, хүйс, үйл хөдлөл-ийг тэмдэглэж, нэг амьтан олон удаа камертаа орсон бол бүгдийг тэмдэглэнэ.

2. Үр дүн (2025 оны эхний хагас жил)

2.1 Нарны өргүүр бүхий автомат худаг

- **Хугацаа:** 2025/06/21 – 2025/08/05 (46 хоног)
- **Нийт зураг:** 1,117
 - Хоосон зураг: 87 удаа
 - Амьтан бүхий зураг: 1,030 удаа (92.2% амжилттай)
- **Цагаар анализ хийхэд:**
 - 80% нь өдрийн 10:00–18:00 цагийн хооронд буусан.
 - Шөнийн 22:00–06:00 цагт 44 зураг буусан бөгөөд Үнэг, Халиун буга, Янгир ямаа ирж байсан.

2.2 Амьтдын бүртгэл

№	Амьтны төрөл	Зургийн тоо	Эзлэх хувь, %
Шувууны баг			
1	Ооч ёл	56	5.437
2	Нөмрөг тас	46	4.466
3	Цармын бүргэд	15	1.456
4	Идлэг шонхор	1	0.097
5	Хадны тагтаа	1	0.097
6	Бөөвөлжин өвөөлж	1	0.097
7	Монгол алтан жигүүр	1	0.097
8	Хадны бор шувуу	1	0.097
9	Хадны жижир	4	0.388
10	Бүжимч чогчиго	1	0.097

№	Амьтны төрөл	Зургийн тоо	Эзлэх хувь, %
11	Хар хэрээ	2	0.194
12	Дагуур гал сүүлт	3	0.291
13	Бор шувууд	724	70.291
Хөхтөн амьтан			
1	Үнэг	11	1.068
2	Янгир	7	0.680
3	Халиун буга	74	7.184
4	Хар сүүлт зээр	5	0.485

4. Тодорхойлолт, ажиглалт

- **Халиун буга (*Cervus canadensis*):**
 - Говь-Алтайд 1.2 бодгаль/км², 480 орчим нийт популяци.
 - Хантайшир нуруунд ажиглалт: 30 бодгаль дуудлагаар, 24 бодгаль шугаман замналын явцад.
 - Нарны өргүүр бүхий уст цэгт 07/24, 07/28 өдөр дайр орж ирсэн.
- **Хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*):**
 - 07/12 өдрийн зурагт Оонь, Янзаганы дүрс буусан.
 - 06/21-нээс нялх амьтан бүртгэгдсэн.
- **Янгир ямаа (*Capra sibirica*):**
 - 01 сарын дунд үеэр 50 амьтан бүртгэгдсэн: 23 тэх, 16 эм ямаа, 11 залуу бодгаль.
 - Камерт 08/01-нд идэр насны тэх, дараа өдрийн 21 цагт 4 ялгаатай бодгаль орсон.
- **Үнэг:** 11 удаа орж ирсэн, шөнийн болон өглөө эрт ирдэг.



Ооч ёл



Цармын бүргэд



Хар хэрээ



Дагуур гал сүүлт



Ооч ёл



Усанд сэрүүцэж буй ооч ёл



Бүжимч чогчиго



Нөмрөг тас



Хадны бор шувуу



Халиун буга



Халиун буга



Халиун буга



Идлэг шонхор



Хадны бор шувуу



Янгир ямаа



Янгир ямаа



Үнэг



Хадны жижир



Үнэг



Нөмрөг тас



Хос цармын бүргэд



Хадны жижир



Ууртай ооч ёл ус мэдрэгчийг гаргаж шидэв



Хадны тагтаа



Хар сүүлт зээрийн оонь



Хар сүүлт зээрийн янзага



Үнэг



Камер суурилуулж байгаа нь



Камер шалгаж буй нь



Малчин иргэн морио услав

2.6.3. Ил уурхайн олборлолтын үед өртөж болзошгүй талбайгаас тарвагыг дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд сэлгэн нутагшуулах ажлыг зохион байгуулах.

Тарвага нь ойт хээр, уулын хээр, тал хээрийн бүсэд өргөн тархсан бөгөөд экосистемийн тогтолцоонд чухал үүрэг гүйцэтгэдэг амьтан юм. Газар нутгийн өнгөн давхаргыг сийрэгжүүлж, хөрсний бүтэц, ургамлын нөмрөгт эерэг нөлөө үзүүлдэг төдийгүй мах идэшт хөхтөн амьтад, шувуудын идэш тэжээл болдог.

Тархац нутгийн зарим хэсэгт өвөлжилт хүнд, шаардлагатай энергийн нөөц хуримтлуулж чадахгүй үед тарвага үхэх, тархац нутаг тасархайтах эрсдэл үүсдэг. Иймд Хан Алтай ресурс ХХК нь Есөнбулаг сумын Наран багт, MV 021537 тоот уурхайн нөлөөллийн бүсэд байгаа тарвагыг өөр газар шилжүүлэн нутагшуулах ажлыг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна.

ҮНДЭСЛЭЛ

- Монгол орны хөхтөн амьтны улаан дансны үнэлгээгээр тарвага “устаж болзошгүй” ангилалд орсон.
- Хууль эрх зүйн үндэслэл: Амьтны тухай хууль (5-р зүйл, 5.3.9; 8-р зүйл, 8.1, 8.2).
- Төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө.

ЗОРИЛГО

Есөнбулаг сумын Наран багт орших Хан Алтай төслийн уурхай орчмын 52 толгой тарвагыг Баян-Уул сумын Алтангадас багийн Ловонгийн нуруу, Есөнбулаг сумын Рашаант багийн Баян-Улаан уулын өвөр Дөрөө булагт шилжүүлэн нутагшуулах, тарваганы нутгийн байршлыг хянан мониторинг хийх.

ҮР ДҮН

1. Бэлтгэл ажил

- Сэргээн нутагшуулах газрыг судалж, хуучин нүх, дошийг сэргээсэн.
- Баян-Уул сумын өмнөх жилүүдийн туршилтын газарт бэлтгэл ажлыг хийсэн.

2. Барьсан тарвага

- Барьсан тарвага: **52 толгой**
 - Эр: 27, Эм: 22, Хотил/Мөндөл: 3
- 4 бүлээс 32 тарвагыг уулын төлөвлөгөөний дагуу шилжүүлэв.

3. Зөөвөрлөлт

- Баян-Уул сум, Ловонгийн нуруунд: 05-р сарын 21
- Есөнбулаг сум, Баян-Улаанд: 05-р сарын 27
- Зөөвөрлөлт, суллан тавих явцад ямар нэг эрсдэл гараагүй.

4. Сэргээн нутагшуулах байршил

- **Баян-Уул сум, Ловонгийн нуруу:** 25 толгой тарвага
- **Есөнбулаг сум, Дөрөө булаг:** 27 толгой тарвага
- Тарвагыг хос хосоор нь суллан тавьж, нутгийн байгаль хамгаалагчидтай хамт хяналт тавьсан.

ДҮГНЭЛТ

- 52 толгой монгол тарвага амжилттай нүүлгэн шилжүүлэгдэв.
- Уурхайн ашиглалтын бүс дэх тарваганы нягтшил өмнөх жилүүдээс сийрэг болсон.
- Говь-Алтай аймгийн зооноз өвчин судлалын төвд 1 тарвагад шинжилгээ хийлгэсэн.
- Сэргээн нутагшуулах ажил нь тарваганы тархац нутгийг хамгаалах, экосистемийн эрүүл тогтвортой байдлыг дэмжихэд чухал.

Зураг 53. Тарвага тээвэрлэх, сэргээн нутагшуулах баг Баян-Уул сум




Зураг 54. Тарвага тээвэрлэх, сэргээн нутагшуулах баг Есөнбулаг сум



Хүснэгт 19. Есөнбулаг сумын Баян-Улааны өвөр Дөрөө булаг гэх газарт шилжүүлэн нутагшуулсан газрын солбицол

№	Өргөрөг	Уртраг	Тарваганы тоо	Нутагшуулсан газар
1	47.154944	95.223722	3	Алтангадас багийн нутаг Ловонгийн нуур
2	47.154514	95.226215	2	
3	47.155202	95.227438	2	
4	47.154532	95.228096	3	
5	47.154771	95.225934	3	
6	47.155422	95.228165	3	
7	47.154872	95.225905	3	
8	47.155117	95.226287	3	
9	47.154354	95.227963	3	
Нийт			25 бодгаль	

Зураг 55. Тарвага тээвэрлэх, сэргээн нутагшуулсан байршил




2.6.4. Ажиллагсад орон нутагт ан хийхийг хориглох, галт зэвсэг болон бусад зэвсэг хэрэгсэл байлгахыг хориглох

Төслийн талбайд ажиллаж буй үндсэн болон гэрээт компанийн ажилчдыг хууль бус ан агнуурын хор хөнөөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг ойлгуулах. Төслийн талбайд тархан амьдарч буй зэрлэг амьтдыг хамгаалах, эрсдэлийг бууруулах мэдлэг, мэдээллээр хангах зорилгоор дараах мэдлэг мэдээллийг хүргэж ажилласан.

1. **Төслийн талбайд бүртгэгдсэн зэрлэг амьтад ба хууль бус агнуурын эрсдэл**
 - 2025 онд хууль бус агнуурт өртсөн нийт амьтад: 181,570.
 - Хувиар: Тарвага – 40%, Чоно – 26.8%, Буга – 15.2%, Хар Сүүлтий – 7.6%, Янгир – 6.4%, Ирвэс – 4%
2. **Хуулийн хариуцлага**
 - Амьтны тухай хууль зөрчсөн тохиолдолд гэм буруутай этгээд амьтанд учирсан хохирлыг нөхөн төлнө.
 - Нөхөн төлбөрийн хэмжээ: амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг Засгийн газраас тогтоосон хэмжээгээр хоёр дахин өсгөн тогтооно.
 - Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүй амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг зөвшөөрөлгүйгээр агнасан тохиолдолд:
 - 5,401 – 27,000 төгрөгөөр торгох, эсвэл
 - 1–5 жилээр зорчих эрхийг хязгаарлах, эсвэл
 - 1–5 жилээр хорих ял оноох.
3. **Экологийн ач холбогдол**
 - Хууль бус ан агнуур нь амьтны тархац, популяц, экосистемийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг.
 - Төслийн талбайд тархан амьдарч буй амьтны популяци, ялангуяа Тарвага, Янгир, Хар Сүүлтий зэрэг хамгаалалттай зүйлсийг хамгаалах нь төслийн байгаль орчны менежментийн зорилттой уялдана.
4. **Ажилчдад зөвлөмж**

- Уурхайн бүс болон ойролцоо ямар ч амьтныг зөвшөөрөлгүй агнахгүй байх.
- Галт болон бусад зэвсэг хэрэглэхгүй байх.
- Байгаль хамгаалагч, мэргэжилтний зөвлөмжийг дагаж ажиллах.

Зураг 56. Хууль бус ан агнуур сургалт



3.1. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтийн дэлгэрэнгүй

3.1.1. Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж, Цөлөрхөг хээрийн шаргал хөрс, Уулын нугын бор, чулуутай хөрс, Уулын нугын хар хөрсөөр 3 ангилан хэлбэржүүлэх, овоолго үүсгэн хадгалах, тэмдэгжүүлэх

Төслийн талбайд олборлолт, бүтээн байгуулалтын үед хөрсний үржил шимийг алдагдуулахгүй хадгалах, нөхөн сэргээлтэд ашиглахад зориулан Шимт хөрсний менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.

Шимт хөрсний ангилалт: Төслийн талбайд хөрсийг хүрээлэн буй орчин, хөрсний шинж чанар, төрөл зүйлээс хамааран 3 ангилалд хуваан хадгална:

1. **Сайр чулуурхаг цайвар хүрэн хөрс** – хээрийн гадаргуугийн хөрс, олборлолт, нөхөн сэргээлтэд хэрэглэнэ.
2. **Уулын нугат хээрийн хөрс** – уулын нуга, хээрийн хэсгийн хөрс, бордоо, нөхөн сэргээлтийн ажилд ашиглахад тохиромжтой.
3. **Уулын нугын хар хөрс** – органик бодис ихтэй, өндөр үржил шимтэй хөрс, нөхөн сэргээлтэд хамгийн үр дүнтэй.

Хуулалт, хадгалалт

- Шимт хөрсийг **MNS 5916:2008** стандарт, дотоод менежмент систем, газрын хөндөх зөвшөөрөл-д тулгуурлан хуулна.
- Хөрсний овоолгыг ус, элэгдлээс хамгаалах, бүтэц нь алдагдахаас сэргийлнэ.
- 2025 онд лицензийн талбай дотор тодорхой үйл ажиллагааны хүрээнд 7 газар, 80,927 м² талбайд хөндөх зөвшөөрөл авсан. Үүнээс 16,185 м³ шимт хөрс хуулсан 2025 оны 3-р улирлын байдлаар 266,120 м³ хөрс овоолгод хадгалагдаж байна:
 - Уулын нугын бор, чулуутай хөрс – **124,837 м³**
 - Цөлөрхөг хээрийн шаргал хөрс – **114,210 м³**
 - Уулын нугын хар хөрс – **27,073 м³**

Хүснэгт 20. Шимт хөрс хуулсан талбай, хэмжээ (2025 он)

Талбай	Талбайн хэмжээ (м ²)	Үйл ажиллагаа
Боловсруулах үйлдвэр нүүрс буулгах талбай	14,510	Нүүрс буулгах
Хансуун бутлуур талбай тэлэх	3,868	Талбай өргөтгөл
Дром талбай сунгах	19,529	Талбай сунгалт
Мужаан цех барих	16,000	Барилга байгууламж
Спорт заал барих	5,800	Барилга байгууламж
Ажилчдын орон сууц барих	6,900	Барилга байгууламж
Хөрсний овоолго тэлэх	14,320	Хөрсний хадгалалт

[illegible]

3.1.2. Хаагдсан замууд, гэрээт бутлууруудын талбайд техникийн нөхөн сэргээлт хийх

“Хан-Алтайн алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах төсөл”-ийн байгаль орчны менежментийн хөтөлбөрийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, экосистемийн тогтвортой байдлыг хангах ажлын хүрээнд уурхайн дотоод ашиглагдахгүй болсон 2.2 км замыг хааж техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Хэрэгцээ, шаардлага: Уурхайн үйл ажиллагааны явцад ашиглагдаж байсан зарим зам, ялангуяа технологийн түр замууд, хүдэр тээвэрлэлтийн чиглэл өөрчлөгдсөн замууд нь ашиглалтгүй болж, байгаль орчинд дараах сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэлтэй болдог. Үүнд:

- Хөрсний эвдрэл, хатаж бутрах, шороон замын нурулт
- Тоосжилт ихсэх
- Ургамлын бүрхэвчийг устгах
- Усны урсац, гадаргын усны нэвчилт өөрчлөгдөх
- Мал, зэрлэг амьтдын байгалийн нутагшил, нүүдэлд сөргөөр нөлөөлөх

Гүйцэтгэсэн ажил: 2025 онд уурхайн дотоод сүлжээнд ашиглагдахгүй болсон нийт 2.2 км урттай замыг хааж, дараах ажлуудыг гүйцэтгэлээ:

- Замын дагуу хөрсийг сийрүүлж, гадаргын хэлбэрийг байгалийн хэв шинжид оруулсан.
- Техникийн нөхөн сэргээлт хийн, хөрсний гадаргын эвдрэлийг багасгах, ургамал ургах нөхцөлийг бүрдүүлсэн

Зураг 59. Төслийн талбайн зам сүлжээ, хаасан зам



3.1.3. Мод үржүүлгийн газарт төслийн талбайн байгалийн бүс бүслүүр, байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон модны үрээр хүлэмжид үрсэлгээ хийх.

2025 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд уур амьсгалд тохирсон, нутгийн унаган ургамлын төрөл зүйлээр нөхөн сэргээх зорилгоор мод үрслүүлэг, үрийн фонд бүрдүүлэх ажлыг дараах байдлаар хэрэгжүүлсэн.

Хүлэмжийн үрслэгээний мэдээлэл

№	Хүлэмжийн дугаар	Үрслүүлсэн модны төрөл	Үрийн хэмжээ (кг)	Нийт үрийн хэмжээ (кг)	Үйл ажиллагаа
1	Хүлэмж 1	Гүйлс	5	15	Усалгааг хийж, арчилгааг гүйцэтгэсэн
		Буйлс	5		
		Монос	5		
2	Хүлэмж 2	Шархуайс	5	10	Усалгааг хийж, арчилгааг гүйцэтгэсэн
		Хайлаас	5		

Бойжуулалт ба мод хүлээлгэн өгөх ажил

- “Хан Алтай” мод үржүүлгийн талбайд бойжуулсан **5000 ширхэг** суулгацыг Говь-Алтай аймгийн Тайшир суманд үйл ажиллагаа явуулж буй “Цэн Газар” ХХК-д хүлээлгэн өгч, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд дэмжлэг үзүүлсэн.
- **Есөнбулаг суманд** Хаврын тарилтаар **6200 ширхэг** суулгац, Намрын тарилтаар **2000 ширхэг** суулгац хүлээлгэн өгч, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд дэмжлэг үзүүлсэн.

Үрийн түүх ба бэлтгэлийн ажил

№	Ургамлын төрөл	Латин нэр	Үр түүсэн байршил	Үрийн хэмжээ	Үрийн боловсруулалт
1	Шинэс	<i>Larix sibirica</i>	Зайврын шинэсэн ой	5 кг	Үрийг хатааж, дэвүүрээс салгах бэлтгэл хийгдсэн
2	Заг	<i>Haloxylon ammodendron</i>	Бигэрийн Заган бүлгэмдэл	2 кг	Үрийг хатааж, дэвүүрээс салгах ажил хийгдсэн

Үрслүүлэг ба суулгац бэлтгэлийн ажил

№	Ургамлын төрөл	Үр/мөчирийн эх үүсвэр	Тарьсан орчин	Тоо хэмжээ
1	Улиас	Бигэр сумын мод үржүүлгийн газар (саваа мөчир)	Хүлэмж	300 ширхэг (харандаа суулгац)
2	Харгана, Хармаг	“Хан Алтай” мод үржүүлгийн газар (2023 онд үрээр үрслүүлсэн)	Бойжуулах талбай	600 ширхэг

Зураг 60. Мод үржүүлгийн хүлэмж, ногоон байгууламжийн ажлын үе шат



Мод үржүүлгийн талбайн зоорь ба дэд бүтэц

“Хан Алтай” мод үржүүлгийн талбайд нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн ажилд зориулж нутаг орондоо түүж бэлтгэсэн үр, суулгац хадгалах зориулалттай зоорийг 20 тонн контейнер ашиглан барьсан. Мөн ажилтны амрах зориулалттай контейнер байр бэлдэж тохижуулсан.

Зураг 61. Мод үржүүлгийн газрын ажилчдын амрах байр, зоорь



3.1.4. Үржил шимт хөрсний үржил шимийг урт хугацаанд хадгалах зорилгоор олон наст ургамлын үр тарьж ургамалжуулах

Шимт хөрсний овоолгыг урт хугацаанд хадгалах, хөрсний чанарыг алдагдуулахгүй байлгах, ургамалжуулалт хийхэд ашиглах шимт хөрсний нөөцийг хамгаалах, байгаль орчны тогтвортой байдлыг хангах зорилгын хүрээнд Уулын нугын бор, чулуутай хөрсний овоолго, Цөлөрхөг хээрийн шаргал хөрсний овоолгыг ургамалжуулах ажлыг гүйцэтгэсэн.

Ангилал ба менежмент:

Хөрсний төрөл	Овоолгын хэмжээ (м³)	Ургамалжуулсан хувь	Ургамалжуулалт	Тайлбар
Уулын нугын бор, чулуутай хөрс	124,837	60%	Ботууль, Хялгана, Ерхөг холимог тарилт	Ургамлын тарилт хөрсний чанарыг хадгалахад чиглэсэн
Цөлөрхөг хээрийн шаргал хөрс	114,210	40%	Ботууль, Хялгана, Ерхөг холимог тарилт	Ургамалжуулалт, нөхөн сэргээхэд ашиглана

Нэмэлт арга хэмжээ:

- Мод үржүүлгийн талбайд 2023 онд хүлэмжид үрслүүлж бойжуулсан нутгийн унаган ургамал болох харганын суулгацыг шилжүүлэн суулгасан

Ач холбогдол:

- Хөрсний тогтвортой байдлыг хангах
- Ургамлын таримал, нутгийн унаган ургамлыг ашиглан нөхөн сэргээх нөхцөлийг дэмжих
- Ургамалжуулалт, нөхөн сэргээлтэд ашиглах боломжийг нэмэгдүүлэх

Зураг 62. Шимт хөрсний овоолго ургамалжуулалт



4.1. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хууль бусаар ашигт малтмал олборлолтын улмаас эвдрэсэн газрыг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх,

Говь Алтай аймгийн Байгаль орчны газраас ирсэн дүйцүүлэн хамгаалах техникийн нөхөн сэргээлтийн ажлын хүсэлтийн дагуу Бигэр сумын Олон булаг багт хууль бус ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд өртөж орхигдсон 8.92 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэгчээр Агат Трейд ХХК шалгарч гэрээ байгуулах ажил хийгдэж байна.

Тус нөхөн сэргээлтийн ажлыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны дотор гүйцэтгэн орон нутагт хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн байна.

Зураг 63. Албан бичгүүд болон ажлын даалгавар



Зураг 64. Эвдрэлд өртсөн байдал



Хүснэгт 21. Техникийн нөхөн сэргээлт хийсэн нийт талбайн мэдээлэл

№	Аймаг, сум	Баг ийн нэр	Нөхөн сэргээлт хийсэн газрын нэр	Эвдрэлд өртсөн төрөл	Нөхөн сэргээлт хийгдсэн он	Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ /га/
1	Говь-Алтай Есенбулаг сум	Баян шанд баг	Шаврын голын сувраганы арын сайр	Хууль бусаар ашигт малтмал олборлолт	2021 он	2 га
2	Говь-Алтай Есенбулаг сум	Наран баг	Бөөрийн ам	Ашиглагдахгүй болсон зам талбай	2022 он	3.2 га
3	Говь-Алтай Есенбулаг сум	Наран баг	Төслийн талбай	Усан хангамжийн нөхөн сэргээлт	2022 он	11.2 га
4	Говь-Алтай Есенбулаг сум	Баян шанд баг	Сувраганы арын сайр	Хууль бусаар ашигт малтмал олборлолт	2022 он	3.52 га
5	Говь-Алтай Есенбулаг сум	Баян шанд баг	Жамбий сайр	Хууль бусаар ашигт малтмал олборлолт	2022 он	1 га
6	Говь-Алтай Есенбулаг сум	Баян шанд баг	Жамбий	Хууль бусаар ашигт малтмал олборлолт	2022 он	0.9 га
7	Говь-Алтай Тайшир сум	Галуут баг	Детийн давааны ам	Хууль бусаар ашигт малтмал олборлолт	2023 он	7.7 га
8	Говь-Алтай Тайшир сум	Галуут баг	Детийн давааны ам	Хууль бусаар ашигт малтмал олборлолт	2024 он	3.35 га
9	Говь-Алтай Бигэр сум	Олонбулаг багт		Хууль бусаар ашигт малтмал олборлолт	2025 он	8.94
Нийт						41.81 га

4.2. Дүйцүүлэн хамгаалалт хийх Зайврын шинэсэн төглийн сэргэн ургалтыг дэмжих, ойн талбайг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Шинэс модны үр бэлтгэх, хүлэмжид үрсэлгээ хийх

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Зайврын шинэсэн төглийн сэргэн ургалтыг дэмжих, ойн талбайг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

1. Шинэс модны үрслүүлэг:
 - 2025 онд 500 грамм шинэс модны үрийг худалдан авч, мод үржүүлгийн талбайд бортогонд үрслүүлж туршилтын ажлыг эхлүүлсэн.
 - Ургалтын эхний үеийн усалгааг тогтмол хийж, ургамлын нөхцөлд тохирсон агааржуулалт, чийгийн зохицуулалтыг хангаж байна.
2. Намрын үр бэлтгэл ба хадгалалт:
 - 2025 оны 10 дугаар сард Зайврын шинэсэн ойгоос 5 кг цагаалаагүй үр цуглуулан бэлтгэсэн.
 - Үрийг стандартын дагуу мод үржүүлгийн талбайн зооринд хадгалсан

Зураг 65. Шинэсний үрсэлгээ /хүлэмж дотор/



Зураг 66. Шинэс модны үр бэлтгэх явц



4.3. Монгол улсын Ерөнхийлөгчийн “Тэр бум мод тарих” санаачилгын хүрээнд Говь-Алтай аймгийн 108сая мод тарих аянд нэгдэн хаврын тарилтаар, мод тарих ажлыг хамтран зохион байгуулах

Монгол улсын Ерөнхийлөгчийн “Тэр бум мод тарих” санаачилгын хүрээнд Говь-Алтай аймгийн 108сая мод тарих аянд нэгдэн Есөнбулаг суманд Хавар, Намрын бүх нийтийн мод тарих арга хэмжээнд дэмжлэг үзүүлж 11200 ширхэг модыг хүлээлгэн өгч хамтран ажилласан.


Хаврын тарилтаар (2025 он) “Хан Алтай” мод үржүүлгийн газарт үрээр үрслүүлсэн 5000 ширхэг суулгац,

Намрын тарилтаар (2025 он) мод үржүүлгийн талбайд үрээр үрслүүлсэн 2000 ширхэг суулгац,

Мөн Говь-Алтай аймгийн Үүр Жимс хоршооноос 3000 ширхэг Улиасны суулгацыг худалдан авч Есөнбулаг сумын намрын бүх нийтийн мод тарих арга хэмжээнд дэмжлэг үзүүлэн Есөнбулаг сумын ЗДТГ-ын байгаль орчны тасагт хүлээлгэн өгсөн.

Хаврын тарилт		Намрын тарилт	
Модны төрөл	Тоо ширхэг	Модны төрөл	Тоо ширхэг
Хайлаас	5000	Хайлаас	1000
Шархуйс	1000	Шархуйс	1000
Агч	100	Улиас	3000
Гүйлс	100		
Нийт	6200	Нийт	5000

Зураг 67. Хавар Есөнбулаг суманд мод хүлээлгэн өгсөн



Зураг 68. Намар Есөнбулаг суманд мод хүлээлгэн өгсөн



Зураг 69. Есөнбулаг суманд мод хүлээлгэн өгсөн акт

**ЕСӨНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ
МОДНЫ СУУЛГАЦ ХҮЛЭЭЛЭГЭН ӨГСӨН АКТ**

2024 он 05 сарын 15-ны өдөр

Монгол улсын Ерөнхийлөгчийн “Тариу мэд” тэрхм үндэсний хяналтын, Говь-Алтай аймгийн 108 сая мод тархж ургуулах хөтөлбөр, “Хан Алтай ресурс” ХХК-ийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд Есөнбулаг сумын Наран багт нийтээр мод тархж арга хэмжээнд дэмжж ургууж Хан Алтай мод ургуулалтын газарт урсгал урсгуулан 6,200 ширхэг модны суулгац 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Есөнбулаг сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Э.Энхбаатар, байгаль хамгаалагч Э.Няндагсүрэн нарт хүлээлгэн өгсөн.

Үүнд:

№	Модны нэр	Өндөр	Нас	Тоо хэмжээ
1	Хайрвас	0.6-1.2 метр	2	5,000 ширхэг
2	Шарууц	0.6-1.2 метр	2	1,000 ширхэг
3	Гүйвэс	0.6-1.0 метр	2	100 ширхэг
4	Алх	0.7-1.5 метр	2	100 ширхэг



Хүлээлгэн өгсөн: “Хан Алтай ресурс” ХХК
БОН-ны ахлах менежер/агч: М.Өсөхбаяр / *M. Osokhbayar*
Байгаль орчны зохицуулагч: П.Сайхансүмбэр / *P. Saikhansumbar*

Хүлээн авсан: Говь-Алтай аймаг Есөнбулаг сум
Байгаль орчны хяналтын улсын байцаагч: Э.Энхбаатар / *E. Enkhbat*
Байгаль хамгаалагч Э.Няндагсүрэн / *E. Nyandagsuren*

**ЕСӨНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ
НАМРЫН ТАРИЛТААР МОДНЫ СУУЛГАЦ ХҮЛЭЭЛЭГЭН ӨГСӨН АКТ**

2025 он 10 сарын 18-ны өдөр

Монгол улсын Ерөнхийлөгчийн “Тариу мэд” тэрхм үндэсний хяналтын, Говь-Алтай аймгийн 108 сая мод тархж ургуулах хөтөлбөр, “Хан Алтай ресурс” ХХК-ийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд Есөнбулаг сумын Наран багт нийтээр мод тархж арга хэмжээнд дэмжж ургууж Хан Алтай мод ургуулалтын газарт урсгал урсгуулан 2 настай 2,000 ширхэг модны суулгац, Говь-Алтай аймгийн Алтайн жимс, жимсгэнэний хамгаалалт 3,000 ширхэг стандарт ширээт хангасан модны суулгацыг 2025 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Есөнбулаг сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Э.Энхбаатар, байгаль хамгаалагч Э.Няндагсүрэн нарт хүлээлгэн өгсөн.

Үүнд:

№	Модны нэр	Нас	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Хайрвас	2-3	1,000 ширхэг	2,500 төг	2,500,000 төг
2	Шарууц	2-3	1,000 ширхэг	2,500 төг	2,500,000 төг
3	Улаас	3-4	3,000 ширхэг	4,000 төг	12,000,000 төг
Нийт			5,000 ширхэг		17,000,000 төг



Хүлээлгэн өгсөн: “Хан Алтай ресурс” ХХК
БОН-ны ахлах менежер/агч: М.Өсөхбаяр / *M. Osokhbayar*
ОХН-ны ахлах менежер/агч: Г.Эрэнцэцэг / *G. Erentsetsag*

Хүлээн авсан: Говь-Алтай аймаг Есөнбулаг сум
Есөнбулаг сумын Засаг дарга Н.Дондогдал / *N. Dondogdal*
Байгаль орчны хяналтын улсын байцаагч: Э.Энхбаатар / *E. Enkhbat*
Байгаль хамгаалагч Э.Няндагсүрэн / *E. Nyandagsuren*

4.4. Орон нутгийн захиргааны байгууллагуудтай дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд зөвшилцон булгийн эхийг хашиж хамгаалах.

Есөнбулаг сумын Наран багт байрлах “Дөвөн” нэрт булгийн эхийг хамгаалж усны урсцыг нэмэгдүүлэн, хуримтлуулах замаар бэлчээрийн ус хангамжийг нэмэгдүүлэх, биологийн төрөл зүйлүүд болон хүн малын тоо хязгаарлагдахгүйгээр бүх амьд организм ундаалах боломж нөхцөлийг хангах ажлын хүрээнд булаг хамгаалах ажлын арга зүй, техникийн үзүүлэлтийн дагуу хийж Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Э.Энхбаатар, Байгаль хамгаалагч Э.Няндагсүрэн, Наран багийн засаг дарга Ө.Нямцэрэн нарт хүлээлгэн өгсөн болно.

Хүснэгт 22. Хамгаалсан булгийн мэдээлэл

1	Байршил Аймаг, Сум, Баг, Газрын нэр	Говь-Алтай аймаг, Есөнбулаг сумын Наран багийн нутаг дэвсгэрт байрлах “Дөвөн” булаг
2	Аж ахуйн нэгжийн нэр, гэрчилгээний дугаар, регистр	Хан Алтай ресурс ХХК, ААН-ийн, РД:6413811
3	Талбайн координат	(N 46° 10' 39"86, E 96° 46' 28.17") (N 46° 10' 40"69, E 96° 46' 25.80") (N 46° 10' 41"87, E 96° 46' 27.30") (N 46° 10' 41"22, E 96° 46' 28.93")
4	Хашиж хамгаалах ажлыг хүлээлгэн өгсөн албан тушаалтан	“Хан Алтай ресурс” ХХК-ийн Байгаль орчны ахлах мэргэжилтэн: М.Өсөхбаяр
5	Зорилго	“Хан Алтай ресурс” ХХК-ийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Наран багт байрлах “Дөвөн” нэртэй булгийн эхийг хашиж хамгаалах замаар урсац, бэлчээрийн ус хангамжийг

		нэмэгдүүлэх, биологийн төрөл зүйлүүд болон хүн мал, амьд организм ундаалах боломж нөхцөлийг хангах,
6	Ажлын хэмжээ	3,094 м2, 205 метр
7	Ашигласан материал	1.5х3м угольник хайрцагласан сеткин тор, 2м төмөр шон, 0.8х1.5м хаалга, мэдээллийн самбар

Зураг 70. Дөвөн булгийн эхийг хашиж хамгаалсан байдал



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ, ЕСӨНБУЛАГ СУМЫН НАРАН БАГТ ХАШИЖ ХАМГААЛСАН
“ДӨВӨН” БУЛГИЙН ЭХИЙГ ХҮЛЭЭЛЦЭХ ТУХАЙ АКТ**

2025.09.11 “Хан Алтай ресурс” ХХК

№	Агуулга	Харуул
1	Байршил: Аймаг, Сум, Баг, Газрын нэр	Говь-Алтай аймаг, Есөнбулаг сумын Наран багийн нутаг дэвсгэрт байрлах “Дөвөн” булаг
2	Ажлын үзлийн нэгжийн нэр, гэрчилгээний дугаар, регистр	Хан Алтай ресурс ХХК, ААН-ийн, РД-6413811
3	Талбайн координат	(N 46° 10' 39" 86, E 96° 46' 28" 17") (N 46° 10' 40' 09, E 96° 46' 25" 80") (N 46° 10' 41' 81, E 96° 46' 27" 10") (N 46° 10' 41' 22, E 96° 46' 28" 93")
4	Хангаж хамгаалах ажлын хүтээлэгч өгсөн албан тушаалтан	“Хан Алтай ресурс” ХХК-ийн Байгаль орчны ахлах мэргэжилтэн М.Өсөлбэр
5	Зардал	“Хан Алтай ресурс” ХХК-ийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сүрьежмэтийг хангах ажлын хүрээнд Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Наран багт байрлах “Дөвөн” нүүрэй булгийн эхийг хангаж хамгаалах замаар урсгал, бүлэгний ус хангажмэтийг нэмэгдүүлэх, биологийн төрөл зүйлүүд болон хүн мал амьд организм ундаалах боломж нөхцөлийг хангах.
6	Ажлын хэмжээ	3,094 м2, 205 метр
7	Ашигласан материал	1.5х3м угольник хайрцагласан сеткин тор, 2м төмөр шон, 0.8х1.5м хаалга, мэдээллийн самбар

Булаг хангаж хамгаалах ажлын тухай:

Есөнбулаг сумын Наран багт байрлах “Дөвөн” нүүрэй булгийн эхийг хангажмэтийг усны урсгал нэмэгдүүлэх, хуримтлуулах замаар байгалийн ус хангажмэтийг нэмэгдүүлэх, биологийн төрөл зүйлүүд болон хүн малын тоо хангажмэтийг нэмэгдүүлэх, амьд организм ундаалах боломж нөхцөлийг хангах ажлын хүрээнд булаг хангажмэтийг усны арга зүй, төхөөрөмж, үзүүлэлтийг дараах хэргийн Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Байгаль орчны хангажмэтийн үйлдвэрч Э.Энхбаттар, Байгаль хангажмэтийн Э.Нэндэгсүрэн, Наран багийн засаг дарга Г.Нямдэрэн нэрт хүлээлэгч өгсөн болно.

Цаашдаа булгийн эхийн замаа хангажмэтийн бүрэн бүтэн байдлын хүтээлэгч тал бүрэн хариуцах болно.

ХҮЛЭЭЛЭГ ҮНӨГСӨН:

ХАН АЛТАЙ РЕСУРС ХХК

Байгаль орчны ахлах мэргэжилтэн: *М.Өсөлбэр*

Орон нутгийн харилцааны зохицуулагч: *Б.Мөнхсала*



ХҮЛЭЭН АВСАН:

Байгаль орчны хангажмэтийн үйлдвэрч: *Э.Энхбаттар*

Байгаль хангажмэтийн: *Э.Нэндэгсүрэн*

Наран багийн Засаг дарга: *Г.Нямдэрэн*

Гүйцэтгэсэн ажлын зураг





Хүснэгт 23. Нийт хашиж хамгаалсан булгуудын мэдээлэл

№	Аймаг, сум	Багийн нэр	Хамгаалсан булгийн нэр	Хамгаалсан огноо
1	Говь-Алтай Есөнбулаг сум	Наран баг	Бөөрийн булаг	2020 он
2	Говь-Алтай Есөнбулаг сум	Наран баг	Бага цахир булаг	2021 он
3	Говь-Алтай Есөнбулаг сум	Наран баг	Элгэн булаг	2022 он
4	Говь-Алтай Есөнбулаг сум	Наран баг	Давааны ус булаг	2023 он
5	Говь-Алтай Есөнбулаг сум	Наран баг	Цахир худаг булаг	2024 он
6	Говь-Алтай Есөнбулаг сум	Наран баг	Дөвөн булаг	2025 он
Нийт				6 булаг

БҮЛЭГ ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Бид “Нийгмийн хариуцлагын гэрээ - 2024”-ын дагуу Орон нутгийг хөгжүүлэх хөтөлбөрөө боловсруулан, түүнийхээ үүрэг амлалтыг хэрэгжүүлэн ажиллалаа.

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Наран баг	Орон нутгийн иргэдээс ирсэн санал гомдлыг тухай бүр шийдвэрлэх	Төслийн нөлөөллийн бүс	Нийгмийн хариуцлагын гэрээ

2024 оны байдлаар 14 айл өрхтэй харилцан тохиролцож “Нөхөн олговрын гэрээ”-г байгуулсан.

2024 онд нүүлгэн шилжүүлэхээр төлөвлөсөн **2 айл өрхөөс** 1 айл өрх “Хан Алтай ресурс” ХХК-аар нүүлгэн шилжүүлэгдэхээс татгалзаж гарах зардлыг мөнгөн хэлбэрээр авах хүсэлт өгч шийдвэрлүүлсэн.

Харин **1 айл өрх** компанийн зардлаар нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх санал гаргаж 2024 онд тус 1 айл өрхийг нүүлгэн шилжүүлэх ажил хийгдсэн.



Зураг 71. Нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц

БҮЛЭГ ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**6.1. Археологийн судалгааны үр:**

2013 онд төслийн хайгуулын XV-015337 лицензтэй талбайд археологийн судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд судалгааны ажлын үр дүнд тусгай зөвшөөрөлтэй талбайн хүрээнд 260 дурсгал илрүүлэн баримтжуулсан байна. Үүнээс 84 хиргисүүр, булш оршуулгын дурсгал 108, хадны зургийн дурсгал 43, чулуун байгууламж 25 байна. Эдгээр дурсгалуудаас булш, хиргисүүрүүдийг хүрэл зэвсгийн үеэс төмөр зэвсгийн түрүү үе, МЭӨ III-I зуун буюу Хүннүгийн үе, МЭ VI-VIII зууны Түрэгийн үед хамааруулсан байна. Мөн хадны зургийн дурсгалуудыг Хүрэл зэвсгийн эхэн үеэс Төмөр зэвсгийн түрүү үед хамааруулж нарийвчлан судлах шаардлагатай гэсэн зөвлөмж өгсөн.

Зарим нэг дурсгал болон соёлын өвийг аль цаг үед хамаарах, түүний түүхийн ач холбогдлыг тодруулан бичээгүй тохиолдол байгаа ба тэдгээрт малтлага, судалгаа хийснээр он цагийн асуудлыг тодорхойлж, түүхийн ач холбогдлыг тодорхойлох боломжтой гэжээ. Ингэснээр соёлын өвүүдийг хэрхэн хамгаалах, цаашид ямар арга хэмжээ авах, хэрхэн ажиллах талаар зөвлөмжийг гаргах боломжтой болох юм.

Судалгааг гүйцэтгэх явцад нийт 16 тооны сүйтгэгдсэн дурсгалууд бүртгэгдэж, тэдгээрийн 11 нь хиргисүүр, 5 нь булш оршуулга бөгөөд шинэ үеийн ашиг хонжоо хайгчид ухаж сүйтгэсэн болохыг олж тогтоосон байна. Энэ жил төслийн талбайд барилгын ажлын бэлтгэлийн үе шатны ажлууд хийгдэх бөгөөд төлөвлөсөн ажлын хүрээнд археологийн ямар нэгэн олдвор өртөхгүй болно. Бэлтгэл ажлын үед түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож холбогдох хуулийн дагуу энэ тухайн сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

6.2. Палеонтологийн судалгааны үр дүн:

XV-015337 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд палеонтологийн судалгааг 2012 онд хийж гүйцэтгэсэн. Судалгааны талбайн хүрээнд хожуу эдиакари-түрүү кембрийн үеийн Арын булаг, Хантайшир, Наран, девоны үеийн Цагаан шороот, мөн палеоген-неогены үеийн Шандгол /Бигэр/, Өөш формацуудын хурдасны гадаргууд илэрсэн хэсгүүдээр сээр нуруугүй болон хөхтөн амьтдын чулуужсан үлдэгдлийн хайгуул хийсэн.

Арын булаг, Хантайшир болон Наран формацуудын хурдас, мөн Цагаан шороот формацын хурдас нь хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн хойд, зүүн хойд хэсгээр өргөн тархалттай.

Харин Палеоген-Неогений үеийн Шанд гол /Бигэр/ болон Өөш формацуудын хурдаснууд талбайн баруун өмнөд хэсгээр буюу Бигэрийн хөндийн хүрээнд өргөн тархалттай байна. Гэхдээ ихэнх хурдас нь плейстоцен-голоцены үеийн саарал өнгийн хажуу, бэл хормойн гаралтай сэвсгэр хурдсаар хучигдсан байдаг.

Судалгааны ажлын явцад Бигэр формацын хурдас дотроос палеонтологийн дээжлэлт явуулахад цөөн тооны жижиг мэрэгч амьтны үүдэн шүд олдсоноос бус, томоохон хэмжээний сонирхолтой олдвор олохгүй байна.

Палеонтологийн судалгааны ажлын үр дүнд манай хайгуулын талбайнуудад палеонтологийн олдвор болох эртний амьтан ургамлын үлдэгдэл илрээгүй тул “Марко Поло” ХХК (Хан Алтай ресурс ХХК-ийн хайгуулын ажлыг хийж гүйцэтгэсэн компани) нь уг тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын ажлыг гүйцэтгэх боломжтой гэсэн дүгнэлтийг гаргаж өгсөн.

Харин цаашид ашиглалтын тусгай зөвшөөрөл авч газар шорооны болон барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх, байшингийн гүнзгий суурь ухах, ойр орчмын газраас нь чулуу, хайрга, элс олборлох зэрэг үйл ажиллагаа эхлэх үеэр сонирхолтой олдвор илэрсэн тохиолдолд ажлаа түр зогсоож, ШУА-ийн Палеонтологийн төвд хандаж, “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн

дагуу авран хамгаалах малтлага хийлгэхийг зөвлөмж болгосныг “Хан алтай ресурс” ХХК -ийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллана.

6.3. Хэрэгжүүлсэн арга хэмжээ: Уурхайн нөлөөллийн бүс дэх соёлын өвийг хамгаалах

Уурхайн талбайд үйл ажиллагааны улмаас нөлөөлөлд өртөх түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа хадны сүг зураг, булш, хиргисүүр дурсгалуудыг хамгаалах зорилгоор тэмдэгжүүлэлт хийж бүртгэв.

Үүнд: Хадны зураг 3, Хиргисүүр 1, Булш 1

Зураг 72. Хадны сүг зураг 1 /Янгир ямаа/



Зураг 73. Хадны сүг зураг 2 /Янгир ямаа/



Зураг 74. Хадны сүг зураг 3 /Янгир ямаа/



Зураг 75. Були хамгаалсан байдал




Зураг 76. Хиргисүүр хамгаалсан байдал



6.3. Хэрэгжүүлсэн арга хэмжээ: Говь-Алтай аймаг орон нутгийн байгууллагаас санал болгосон соёлын өвийг хамгаалах

Хан Алтай ресурс ХХК-ийн Говь-Алтай аймгийн Засаг дарга, Есөнбулаг сумын Засаг дарга нартай байгуулсан Нийгмийн хариуцлагын гэрээ, 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний хүрээнд Емөнбулаг сумаас мрсэн хүсэлтийн дагуу Буган чулуун хөшөө, хиргисүүр бүхий 2 цогцолбор дурсгалд хашаа, хайс, хаяг самбар хийх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхээр ажлын даалгавар боловсруулан гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт хийгдэж байна.

№	Сумын нэр	Багийн нэр	Дурсгалт газрын нэр	Хашиж хамгаалах талбайн хэмжээ / 48 метр /
1	Есөнбулаг сум	Жаргалант баг	Хадаасангийн эх Буган чулуун хөшөө бүхий цогцолбор дурсгал	24 метр
2			Хадаасангийн эх Хиргисүүр бүхий цогцолбор дурсгал	24 метр



Зураг 77. Хашиж хамгаалах буган чулуун хөшөө, хиргисүүд бүхий цогцолбор

БҮЛЭГ ДОЛОО. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

7.1. Осол эрсдэлээс сэргийлэх, ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний журмууд:

Хан алтай төслийн талбайд осол эрсдэлээс сэргийлэх, ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 28 журам, 5 заавар, 4 төлөвлөгөө, 3 дүрмийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Зураг 78. Осол, эрсдэлийн журмууд

1	Авто тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлага	21	Зэрлэг амьтдын ажиглалт, хяналт шинжилгээний журам
2	Алжаал ядаргааны менежментийн журам	22	Ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээний журам
3	Асгаралтын үед мөрдөх журам	23	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөлийн ажиллах журам
4	Аяллын удирдлагын журам	24	Уурхайн тээврийн хэрэгсэл болон тоног төхөөрөмжид дугаарлалт, хаягжуулалт хийх заавар
5	Газар хөндөх, үржил шимт хөрс хуулах, хадгалах журам	25	ЭМААБО-ны баримт бичгийн хяналтын журам
6	Галын аюулгүй байдлын журам	26	Онцгой байдлын үед ажиллах заавар
7	Замын хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөө	27	Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг ашиглах, хадгалах заавар
8	Орон нутгийн харилцааны журам	28	Гал унтраагуур ашиглах, хадгалах заавар
9	Осол зөрчлийн удирдлагын журам	29	ГОҮХҮБ-ийн үйл ажиллагааны заавар
10	Согтууруулах ундаа ба мансууруулах бодисыг зохицуулах журам	30	Булгийн эхийг хамгаалах, ажлыг хянах журам
11	Төрийн байгууллагатай харилцах журам	31	Гадаргын уснаас дээж авах, усны чанарын хэмжилт судалгаа хийх журам
12	Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны журам	32	Агаарын тоосны хяналт шинжилгээ явуулах, дээж авах журам
13	Уурхайн талбайн шалган нэвтрүүлэх журам	33	Хөрснөөс дээж авах, тээвэрлэх, тайлагнах журам
14	Хаалт хашилт, тэмдэг тэмдэглэгээний журам	34	Хаягдал чулуулгийн дээжлэлт явуулах, дээж авах журам
15	Ахуйн болон аюултай хог хаягдлыг зохицуулах журам	35	Аюул эрсдэлийн удирдлагын журам
16	Хувийн хамгаалах хэрэгсэл сонгож авах, хэрэглэх, хадгалах, устгах журам	36	Амь нас хамгаалах алтан дүрэм
17	ЭМААБО-ны сургах, мэдлэг, ур чадвар олгох тухай сургалтын журам	37	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө
18	Яаралтай Тусламжийн нэгжийн ажиллах журам	38	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ
19	Явуулын худалдаа эрхлэх журам	39	Аюулгүй байдлын зөрчил гарсан үед хэрэгжүүлэх төлөвлөгөө
20	Аюултай хог хаягдал тээвэрлэх, шилжүүлэх, устгах журам	40	Химийн хорт болон аюултай бодисын холбогдолтой ослын үед ажиллах төлөвлөгөө

7.2. Гэнэтийн ослын үед хариу үзүүлэх сургалт дадлага:

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль, Гал түймэр унтраах дүрэм болон холбогдох бусад хууль, норматив баримт бичгийн хэрэгжилтийг хангах, уурхайн талбайд тохиолдож болзошгүй гамшиг, ослын үед шуурхай хариу арга хэмжээ авах чадварыг нэмэгдүүлэхэд энэхүү дадлага сургалт чиглэгдсэн.

- Объектод гарч болзошгүй гал түймэр, ослын үед шийдвэр гаргах, арга зүйн тактикийн ур чадварыг дээшлүүлэх,
- Шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийн тооцооллыг зөв гаргах,
- Онцгой байдлын байгууллагууд болон уурхайн ажилтнуудын хамтын ажиллагааг сайжруулах,
- Сэтгэл зүйн бэлтгэл, аврах ажиллагааны зохион байгуулалт, багаж хэрэгслийн ашиглалт зэрэг чиглэлээр дадлагажуулахад оршино.

Сургалтын зохион байгуулалт

- Зохион байгуулагч байгууллагууд:
 - “Хан Алтай ресурс” ХХК
 - Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газар
- Оролцогчид: Гамшгаас хамгаалах штабын бие бүрэлдэхүүнээс 12 ажилтан
- Сургалтын хэлбэр: Онол ба дадлага хосолсон
- Хугацаа: 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр
 - Эхэлсэн цаг: 14:00
 - Дууссан цаг: 18:30
- Нийт үргэлжлэх хугацаа: 6 цаг

Сургалт дараах үндсэн хэсгүүдийг хамарч явагдсан:

1. **Онолын хэсэг**
 - Гамшгаас хамгаалах, галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, журам
 - Уурхайн онцлогт тохирсон гал түймрийн эрсдэлийн үнэлгээ
 - Гал түймэр болон ослын үед команд, штабын ажиллагаа зохион байгуулах зарчим
 - Хүн хүч, техник хэрэгслийн тооцоолол, ослын үед мэдээлэл дамжуулах журам
2. **Дадлагын хэсэг**
 - Гал түймрийн дуудлагад түргэн хариу арга хэмжээ авах
 - Уурхайн ажилчидтай хамтран аврах ажиллагаа зохион байгуулах
 - Гал унтраах техник, багаж хэрэгслийн ашиглалт, гал унтраах дадлага хийх
 - Гэмтэж бэртсэн иргэнд анхны тусламж үзүүлэх

Сургалтын үр дүн

- Сургалтад оролцогчид гамшгийн үед хариу арга хэмжээ авах ур чадварыг дээшлүүлсэн.
 - Уурхайн ажилчид болон Онцгой байдлын газрын алба хаагчдын хамтын ажиллагаа сайжирсан.
 - Бие бүрэлдэхүүний хариу арга хэмжээний зохион байгуулалт, шийдвэр гаргах чадвар, техник хэрэгслийн ашиглалт сайжирсан.
 - Сургалтын төгсгөлд дадлага амжилттай дүгнэгдэж, оролцогчдод Онцгой байдлын газрын үнэлгээний тайлан, зөвлөмж хүргүүлсэн.
-

Зураг 79. Гэнэтийн ослын үел хариу үзүүлэх дадлага



7.3. Анхны тусламжийн сургалт дадлага:

Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэгийг нэмэгдүүлэх, осол гэмтлийн үед шуурхай арга хэмжээ авч чадах чадварыг дээшлүүлэх зорилгоор Говь-Алтай аймгийн Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран “Ажлын байранд анхны тусламж үзүүлэх сургалт”-ыг зохион байгууллаа.

Сургалтын зохион байгуулалт

- Сургалтын хэлбэр: Танхим болон дадлага хосолсон
- Давтамж: 2 удаа
- Хугацаа: 2025 он
- Сургалтын байгууллага: Улаан загалмайн нийгэмлэгийн сургалтын баг

Хамрагдалт ба оролцоо

- Нийт хамрагдсан идэвхтэн гишүүдийн тоо: 61
- Нийт сургалтын хүн/цаг: 488 хүн/цаг
- Сургалтад уурхайн үндсэн болон гэрээт компанийн төлөөлөл, ажлын байрны хариуцлагатнууд, анхны тусламжийн багийн гишүүд хамрагдсан.

Сургалтын агуулга

Сургалтыг **онол ба дадлага хослуулсан хэлбэрээр** явуулж, дараах үндсэн сэдвүүдийг хамарсан:

1. Анхны тусламжийн зорилго, зарчим
2. Осол гэмтлийн үед үзүүлэх анхан шатны тусламж
3. Цус алдалт, шокийн үед авах арга хэмжээ
4. Яс хугарал, зөөлөн эдийн гэмтэлд үзүүлэх тусламж
5. Амьсгалын замын бөглөрөл, ухаан алдалт, зүрх судасны сэргээлт (CPR)
6. Гал түймэр, цахилгааны ослын үед авах анхны арга хэмжээ

Сургалтын үр дүн

- Сургалтад хамрагдсан ажилчид **анхны тусламж үзүүлэх онолын мэдлэг, дадлага ур чадварыг эзэмшсэн.**
- **Бие даан болон багаар ажиллах чадвар** нэмэгдэж, осол гарсан тохиолдолд шуурхай хариу арга хэмжээ авах мэдлэг олж авсан.
- Сургалтад хамрагдсан нийт 61 гишүүнд гэрчилгээ гардуулан өгсөн.

Сургалт нь уурхайн хэмжээнд ажиллагсдын аюулгүй ажиллагааны мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлж, анхны тусламжийн соёлыг төлөвшүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан. Цаашид энэхүү сургалтыг жилийн төлөвлөгөөт сургалтын хөтөлбөрт тогтмол оруулах, шинэ ажилтнуудыг үе шаттайгаар

Зураг 80. Анхны тусламжийн сургалт



7.4. Химийн бодисын эрсдлийн үнэлгээ

ЭРСДЭЛИЙГ ХЯНАХ, СЭРГИЙЛЭХ

АГААР - 10 ЦЭГ



Агаар дахь нийт болон чөлөөт
Цианитын хэмжээг сар тутам
тодорхой цэгүүдэд мониторинг
хийх

ХӨРС – 11 ЦЭГ




Хөрсөн дахь нийт болон чөлөөт
Цианитын хэмжээг сар тутам
тодорхой цэгүүдэд мониторинг
хийх


АМЬТАН
7 ХОНОГ БҮР



Мэрэгч, хөхтөн амьтан болон
шувуу нуруулдан уусгах
байгууламж болон ХБҮ-рүү
орохоос сэргийлж хашаа
хамгаалалт хийх, шувуу үргээгч
байрлуулах



ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ



Зураг 81. Эрсдэлийг бууруулах арга хэмжээ

7.5. Натрийн цианидын ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээ:

1 МЭДЭГДЭХ, БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ Ахлах ажилтан, онцгой байдлын багт мэдэгдэх. Гэмтсэн хүмүүст туслах түргэн тусламж дуудах.	2 ТУСГААРЛАХ Асгарсан талбайг тусгаарлана. Шинжилгээ, саармагжуулалтыг хийнэ.	3 АГУУЛАХ Химийн хорт болон аюултай хог хаягдал хагдалах цэгт зориулалтын саванд хадгална.
4 СААРМАГЖУУЛАХ, ДАХИН ШАЛГАХ Саармагжуулсан хөрс, химийн бодист дахин шинжилгээ хийнэ.	5 АРИУТГАХ Бодхирдсон хөрсийг хуулж гипохлоридоор саармагжуулж ариутгана.	6 ОНЦ БАЙДАЛ ҮҮССЭН ҮЕД Хэрвээ онц байдал үүсвэл голомтыг нэн даруй орхиж, ОБЕГ болон түргэн тусламж дуудна.

8652-9696

105






Зураг 82. Натрийн цианидын ослын үеийн төлөвлөгөө

БҮЛЭГ НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

8.1. Энгийн хог хаягдлыг ангилан ялгах хогийн савны тоо хэмжээг нэмэгдүүлэх.

Байгаль орчны багийн “ХАМТДАА 2025”, “Хог хаягдлын менежментийг сайжруулах” аяныг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хоёр сарын хугацаанд Хан Алтай төслийн талбайд зохион байгуулан, үндсэн болон гэрээт компаниудын дунд өрнүүлэн хэрэгжүүлээ.

Аяны хүрээнд хэрэгжсэн “Хог хаягдлаа ангилан ялгая” багийн уралдаанд үндсэн болон гэрээт компанийн бүх газар, хэлтэс, нэгжүүд оролцож, өөрсдийн хариуцсан талбайд гадаа болон дотор ангилан ялгах хогийн савыг байршуулан, хог хаягдлын зохистой менежментийг сайжруулсан.

Аянд оролцсон үндсэн хэлтэс, нэгжүүд: Кемп, дэд бүтцийн хэлтэс, Боловсруулах үйлдвэрийн хэлтэс, Бутлуурын хэлтэс, Худалдан авалт, хангамжийн хэлтэс, Уул ашиглалтын хэлтэс, Техник, засвар үйлчилгээний хэлтэс, Цахилгааны хэлтэс

Аянд оролцсон гэрээт компаниуд: “Мастер Фүүдс” ХХК, “Топ Бүлэг” ХХК, “Хансуун Бутлуур” ХХК, “Габсу Бутлуур” ХХК, “Макс Рөүд Бутлуур” ХХК, “Нитросибирь Монголиа” ХХК

Зураг 83. Ангилан ялгалтын стандарт хогийн сав нэмэгдүүлсэн байдал



Зураг 84. Ангилан ялгалтын хогийн сав гарын доорх материал ашиглан нэмэгдүүлсэн байдал



8.2. Энгийн болон дахивар хог хаягдал хүлээн авах эрх бүхий аж ахуйн нэгж байгууллагатай хог хаягдлын гэрээ байгуулж үүссэн хог хаягдлаа тогтмол зайлуулах.

Хан Алтай төслийн хэмжээнд энгийн хог хаягдлыг Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 23 дугаар тогтоолын хавсралт “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын дагуу ангилан ялгаж, цуглуулан, албан журмын дагуу зайлуулж байна.

